

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ХОЛБОГДОХ
ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦАД ХИЙСЭН ҮНЭЛГЭЭ**

2016 оны эхний хагас жилийн байдлаар.

/Хүснэгт-1/

	Бүгд	Үүнээс							
		Монгол улсын хууль	УИХ-ын тогтоол	УИХ-ын байнгын хорооны тогтоол	Ерөнхийлөгчийн зарлиг	Засгийн газрын тогтоол	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	Ерөнхий сайдын захирамж	ҮАБЗ-ийн зөвлөмж
Хяналтанд авсан тогтоол шийдвэрийн тоо	58	5	9	2	3		34	1	4
Хяналтанд авсан нийт зүйл заалтын тоо	128	10	12	7	7	37	42	1	12
Үүнээс	Биелсэн 100.0%	24	1	2			8	12	1
	Хэрэгжих шатанд:	103	9	10	7	7	29	30	11
	90,0%	36	1	2	1	4	13	12	3
	70,0%	30	1	2	4	3	9	10	1
	50,0%	12		3	2		3	1	3
	30,0%	10	5				1	1	3
	10,0%	5		1				4	
	Хугацаа болоогүй	7	1	1			3	2	
	Дүгнэгдээгүй	2		1					1
Тасарсан	2	1						1	
ДҮН	73.0	45.6	68.0	67.1	81.4	81.8	77.5	-	56.7

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛ ОРУУЛЖ БҮЙ ЗААЛТУУДЫН ТОВЧОО**

/Хүснэгт-2/

Д/д	Эрх зүйн баримт бичиг	Шийдвэрийн тоо	Зүйл заалтын тоо
1	Монгол Улсын хууль	1	1
2	Ерөнхийлөгчийн зарлиг	1	3
3	Улсын их хурлын тогтоол	4	5
4	Ерөнхий сайдын захирамж	1	1
	ҮАБЗ-ийн зөвлөмж	2	2
5	Засгийн газрын тогтоол	12	15
6	Засгийн газрын хуралдааны тэмдэглэл	18	22
	Нийт	39	49

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН
ХЯНАЛТААС ХАСАХ САНАЛ ОРУУЛЖ БУЙ ЗААЛТУУДЫН АГУУЛГА**

/Хүснэгт-3/

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	№	Зүйл, заалтын дугаар, агуулга	Хяналтаас хасуулах шалтгаан	Үнэлгээ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ					
1	Тариалангийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-01-29	1	21.1.Тариалангийн үйлдвэр-лэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг Засгийн газар батална.	Бүрэн хэрэгжсэн тул хасах саналтай.	100
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ					
2	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тухай 2010.11.29 №250	2	1.1.Сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг чиглэл болгосугай. Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих хөтөлбөр”, “Малын тэжээл”, “Экологийн цэвэр бүтээгдэхүүн”, “Сүү” хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, нийслэл болон томоохон суурин газрын орчим сүүний чиглэлийн фермерийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлэхэд шаардагдах газар зохион байгуулалт, бэлчээрийн хуваарилалтыг шинэчлэн зохион байгуулах, сүүний фермерүүд хоршиж тэжээлийн ургамал тариалах, хадлан тэжээл бэлтгэж нөөцлөх, тэжээлийн болон даршны үйлдвэрлэлийг дэмжих, сүүний чиглэлийн үхрийн генофондыг сайжруулах, өсвөр үхрийг технологийн дагуу бойжуулах, сүү хүлээн авах, хадгалах, тээвэрлэх үеийн эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах, хуурай сүүний үйлдвэр байгуулах, сүү нөөшлөх технологи нэвтрүүлэх, сүүний нөөц бүрдүүлэх зэрэг чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;	Хэрэгжилт тогтмолжсон тулхасах саналтай.	90
		3	1.2.Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангах, хүнсний ногооны нэр төрлийг олшруулж, сортыг сайжруулах, усалгаатай тариаланг нэмэгдүүлэх, төмс, хүнсний ногоог боловсруулах, нөөшлөх үйлдвэрлэлийг өргөжүүлэх, агуулахын аж ахуйг хөгжүүлэх, үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд борлуулалт хийх орчинг бүрдүүлэн тэдний харилцан холбоог ойртуулах;	Хэрэгжилт тогтмолжсон тулхасах саналтай.	90
		4	1.4. “Чацаргана” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, жимс, жимсгэнэ тариалах, боловсруулах жижиг дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх /ХҮБХЗГ, ГТБХЗГ/	Хэрэгжилт тогтмолжсон тулхасах саналтай.	90
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ					
3	Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2012.12 № 67	5	1.3.стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрлийн хураамж, түүний хэмжээг тогтоохтой холбогдсон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх саналаа 2013 оны 01 дүгээр сард багтаан Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд ирүүлэх. /СБТГ/	Хасах саналтай байна.	100

4	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2014.11.13 № 69	6	3.5.Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг зах зээлийн зарчимд шилжүүлэх замаар иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүү-лэлтийн тогтвортой тогтол-цоог бий болгож, хөтөлбөрөөс үе шаттай гарах арга замыг сонгож хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай. /СБТГ, ХҮБХЗГ/	Хугацаан хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	70
5	Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015 он № 69	7	1.1.2014 оны төсвийн орлого, төсвийн тэнцэл, Засгийн газрын өр нь Төсвийн тогтвортой байдлын тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуулиудыг зөрчсөнд дүгнэлт хийж, цаашид хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах /СБТГ/	Хасах саналтай байна.	100
6	Хөдөө аж ахуйн “Халх гол” чөлөөт бүс байгуулах тухай 2015 он № 75	8	3.1.“Халх гол” чөлөөт бүсэд дагаж мөрдөх технологийн болон амьтан, ургамлын хорио цээрийн журмыг батлан, хэрэгжилтийг зохион байгуулах; /СБТГ, Халх гол төсөл/	Хүчингүй болсон тул хасах саналтай байна.	50
		9	3.2.“Халх гол” чөлөөт бүсэд хөдөө аж ахуйн тогтвортой хөгжлийн загвар, шинжлэх ухаанд суурилсан байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;	Хүчингүй болсон тул хасах саналтай байна.	-
ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ					
7	Ажлын хэсэг байгуулах тухай 10/30/2015, №: 213	10	2 Мал болон махан бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлоход бүх талын дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, явц, үр дүнг танилцуулж байхыг ажлын хэсэг (Д.Батцогт)-т даалгасугай	Хамааралгүй тул хасах саналтай байна.	-
ҮАБЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ					
8	Том төрөөс ухаалаг төр рүү 2013-12-20 №: 52/32	11	4 Төрийн байгууллагуудад: Байгууллагадаа ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг явуулж, 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тодорхой ажлыг хариуцах эзэн, тодорхой хугацаатайгаар тусган хэрэгжүүлж, дээд шатны болон аудитын байгууллага, олон нийгэд тайлагнах /ТЗУГ/	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	90
9	Олон улсын гэрээ байгуулах үйл ажиллагааг сайжруулах тухай 2014 46/26	12	1. Улс хоорондын болон Засгийн газар хоорондын гэрээ байгуулахдаа дараах журмыг чанд баримтлах: 1.1.Гэрээ байгуулахдаа үндэсний язгуур ашигсонирхолыгүндэс болгох; 1.2.Гэрээг Үндсэн хууль болон бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд нийцүүлэх; 1.3.Гадаад харилцааны сайд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дугаар хэсгийн 4-т заасны дагуу гэрээ байгуулах чиглэлээр үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, гол хариуцлага хүлээх; 1.4.Тодорхой гэрээ байгуулах асуудлаар Гадаад харилцааны яамтай зөвшилцөн төсөл, орчуулгыг нь албан ёсоор хянуулж дүгнэлт гаргуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байх; 1.5.Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5.10, 5.11-д заасныг баримтлан гэрээний төслийг заавал монгол хэлээр үйлдэх. 2.Байгууллага хоорондын гэрээ байгуулахдаа Гадаад харилцааны яамны санал, дүгнэлтийг авч, байгуулсан гэрээг Гадаад	Хасах саналтай байна.	100

			харилцааны яаманд бүртгүүлэх. 3.Гэрээ байгуулахаар яриа хэлэлцээ хийхдээ "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай" Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01/01 дүгээр зөвлөмж болон Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-ыг мөрдлөг болгох. /ГХАХ/		
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ					
10	Хүнсний аюулгүй байдлыг хангах, архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2008 №04	13	1. Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүнсний тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай зэрэг хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ, Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. /ХҮБХЗГ/	Хэрэгжилт тогтмолжсон тул хасах саналтай	100
11	Автобензин, дизелийн түлш, мах, нийтийн тээврийн үнийг тогтворжуулах зарим арга хэмжээний тухай 2012 № 53	14	8. Гахай, шувууны мах, загас, загасан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, импортыг нэмэгдүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, нийслэлийн Засаг дарга Г.Мөнхбаяр нарт үүрэг болгосугай. /ХҮБХЗГ/	Хасах саналтай байна.	100
12	Журамд өөрчлөлт оруулах тухай 2015.02.02 № 40	15	2.“Улсын сайн малчин”, “Улсын тэргүүний фермер”, “Улсын тэргүүний малчдын бүлэг”, “Улсын тэргүүний тариаланч хамт олон”, “Улсын тэргүүний тариаланч” шагналыг төсвийн багцдаа багтаан олгож байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад үүрэг болгосугай.	Хасах саналтай.	100
13	Монгол Улсын 2015 оны төсвийн хэрэгжилтийг хангах зарим арга хэмжээний тухай 2015 № 109	16	7. Дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг бүх шатны төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай: 7.1. Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд заасан орлогын төлөвлөгөөг баталсан хуваарийн дагуу оны эхнээс жигд ханган биелүүлэхэд онцгой анхаарч, үйл ажиллагаагаа зохион байгуулах; 7.2. Урсгал зардлыг хэмнэх, төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2014 оны 147 дугаар тогтоол болон энэхүү тогтоолд нийцүүлэн баталж, харьяа төсөвт байгууллагуудад мөрдүүлж ажиллах. /СБТГ/	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	90
14	Тогтоолын хавсралт шинэчлэн батлах тухай 2015 № 135	17	2. Хавсралтад заасан төслүүдийг БНХАУ-ын Засгийн газарт санал болгох, төслийг цаг хугацаанд нь үр дүнтэй хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, холбогдох сайд нарт даалгасугай.	Хасах саналтай.	100
15	Бүтэц, зохион байгуулалтын зардлын талаар авах зарим арга хэмжээний тухай 2015.07.07 № 281	18	2.Энэ тогтоолын 1 дүгээр зүйлд заасан хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж, хуульд заасны дагуу тайлагнахыг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай. /СБТГ/	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	90
16	Үрийн болон хүнсний улаан буудайн стратегийн нөөц бүрдүүлэх тухай	19	1. 2015 оны намар аж ахуйн нэгжүүдийн хураан авсан стандартын шаардлага хангасан хүнсний улаан буудайг гурилын үйлдвэр болон Тариалан эрхлэлтийг дэмжих санд, аж	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах	90

	2015.08.03 № 322		ахуйн нэгжүүдэд 2016 онд шаардагдах хэрэгцээнээс илүү гарсан шаардлага хангасан үрийн улаанбуудайг улсын нөөц болон Тариалан эрхлэлтийг дэмжих санд тус тус худалдан авах ажлын бэлтгэлийг хангаж, зохион байгуулан ажиллахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Хүнс хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгасугай.	саналтай.	
		20	2. Ургацын урьдчилсан баланс гарсны дараа шаардлагатай бол хүн амын гурилын эрэлт, хангамжийг тогтворжуулах зорилгоор стратегийн хүнсний нөөц бүрдүүлэхэд шаардагдах хүнсний болон үрийн улаанбуудайг гадаад зах зээлээс гэрээ шууд байгуулах аргаар худалдан авч нөөцлөхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад үүрэг болгосугай.	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	50
		21	3.Хүнсний болон үрийн улаанбуудай нөөцлөхөд шаардагдах 80.0 (наян) тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөн-гийн зээлийн эх үүсвэрийг бүрдүүлэхийг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгаж, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл (Б.Шинэбаатар)-д зөвшөөр-сүгэй.	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	70
17	Зуншлагын байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015.08.03 №323	22	2.Уур амьсгалын хуурайшилт, гантай болон гандуу байснаас ургац алдсан үр тарианы чиглэлийн аж ахуйн нэгжүүдийн бэлтгэсэн ногоон тэжээл, рапсын шахдасыг улс, аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөцөд худалдан авч, малын тэжээлийн нөөц бүрдүүлэх болон өвс хаман боогч 20 ширхэгийг худалдан авахад шаардагдах 8.658.0 /найман тэрбум зургаан зуун тавин найман/ сая төгрөг, өвөлжилт хүндэрч болзошгүй аймгуудын улсын нөөцийн өвс, тэжээлийн цэг, салбаруудад малын хүчит тэжээл худалдан авч байршуулахад шаардагдах 2.010.3 /хоёр тэрбум арван сая гурван зуун мянган/ сая төгрөг, нийт 10.668.3 /арван тэрбум зургаан зуун жаран найман сая гурван зуун мянган/ сая төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээлийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Шадар сайд У.Хүрэлсүх, Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөл /Б.Шинэбаатар/-д даалгаж, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргалд зөвлөсүгэй.	Хасах саналтай.	90
		23	3.Энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан бараа бүтээгдэхүүнийг шууд гэрээ байгуулах аргаар худалдан авах арга хэмжээг авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгасугай. /СБТГ, ГТБХЗГ, ХҮБХЗГ, МААБХЗГ/	Хасах саналтай.	90
18	Дунд хугацааны стратеги батлах тухай 2015.10.05 № 396	24	Дунд хугацааны стратегийн зорилт, арга хэмжээг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, харьяа нутаг дэвсгэртээ хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга болон аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.	Хасах саналтай.	100
19	Малчдыг дэмжих зарим арга хэмжээний тухай 2016.02.04 №90	25	3 Малчдын үйлдвэрлэж байгаа түүхий эд, бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, малын халдварт өвчнөөс ангид эрүүл бүс байгуулах, малын гаралтай бүтээгдэхүүний	Хасах саналтай байна.	100

			экспортыг нэмэгдүүлэх замаар малчдын орлогыг сайжруулж, санхүүгийн дэмжлэг үзүүлэх асуудлыг шийдвэрлэх зорилго бүхий хөтөлбөрийн төсөл боловсруулж 2016 оны I улиралд багтаан Засгийн газарт оруулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Сангийн сайд Б.Болор, Хөдөлмөрийн сайд Г.Баярсайхан нарт даалгасугай.		
20	Улаанбурхан өвчний дэгдэлттэй холбоотой авах зарим арга хэмжээний тухай 2016-04-18 №: 222	26	3 I хүртэлх насны хүүхдийг халдварт өртөхөөс сэргийлэх, эцэг, эхчүүд хүүхдээ гэртээ асрах боломж олгох зорилгоор ажил, хөдөлмөр эрхэлж байгаа 0-1 насны хүүхэдтэй эхчүүдэд 2016 оны 7 дугаар сарын 1-ний өдрийг хүртэлх хугацаанд Хөдөлмөрийн тухай хуулийн 103 дугаар зүйлд заасан хүүхэд хөхүүлэх, асрах завсарлага дээр нэмж цалинтай чөлөө олгох арга хэмжээ авахыг ажил олгогч нарт үүрэг болгосугай.	Хасах саналтай.	100
ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ					
21	2012.10.06 № 60	27	67.2.2. Хуралдаан дээр Засгийн газрын гишүүдээс гаргасан саналын дагуу Тариаланг дэмжих сангийн үйл ажиллагаанд шалгалт хийх, хүнсний буудайг гурилын үйлдвэр болон Тариаланг дэмжих санд худалдан авахдаа сорт, чанараас хамаарч нэг ижил үнэ мөрдөх, Тариаланг дэмжих сангийн үйл ажиллагааг хувийн хэвшлийн оролцоо бүхий корпораци болгох асуудлыг судалж, санал боловсруулах зэрэг арга хэмжээ авахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулгад даалгав. /СБТГ, ГТБХЗГ/	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	70
22	2013.03.02 № 11	28	XXI.183.3.2. Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газраар хэлэлцүүлэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх арга хэмжээ авахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Х.Баттулга, Сангийн сайд Ч.Улаан нарт даалгав. /СБТГ/	Хасах саналтай	100
23	Мянганы хөгжлийн зорилт 2015.04.06 №19	29	“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд удааширч байгаа зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. /ХШҮДАГ/	Хүчингүй болсон тул хасах саналтай байна.	90
24	2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2015 оны төлөвлөгөөг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2015.04.27 № 23	30	2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлийг гаргуулан хянан баталгаажуулах, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулах. /СБТГ/	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	70
25	Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл 2015.5.18 № 28	31	XXII. Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд үзэл баримтлалыг баталж, хуулийн төслийг орон нутгийн захиргааны байгууллага болон тариалан эрхлэгчдийн саналыг авч тусган боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Хасах саналтай.	100

26	Үндэсний хөтөлбөрүүдийн 2014 оны хэрэгжилтийн нэгдсэн дүн 2015.06.29 №39	32	XXXII.1. Эрхэлсэн асуудлын хүрэн дэх зорилго, зорилт нь давхардаж байгаа хөтөлбөрүүдийг нэгтгэж, 2015 онд хэрэгжиж дуусах хөтөлбөрийн биелэлтэд үнэлгээ өгч, хэрэгжилт нь удааширсан буюу тасарсан хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар тодорхой санал боловсруулан засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. /ХҮБХЗГ, ГТБХЗГ, МААБХЗГ/	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	100
27	Хүнсний улаанбуудайг гурилын үйлдвэрт нийлүүлэх тухай 2015.08.24 №48	33	XI.2.Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа 2015 оны ургацын урьдчилсан балансын дүнг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан ургац хураалтын бэлтгэлийг сайтар хангуулж, хүнсний улаанбуудайг гурилын үйлдвэрт нийлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав. /ГТБХЗГ/	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай байна.	90
28	2015 оны 08 дугаар сарын 31-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 8/31/2015 № 49	34	XIII.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов: 1.1. биелэлт удаашралтай байгаа 31 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.2. зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой заах /ХШҮДАГ/	Хасах саналтай.	100
29	Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай	35	XIII. “Үндэсний үйлдвэр-лэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төсөл.	Хасах саналтай.	100
30	Ургац хураалтын талаар 2015.11.02 № 60	36	XXXI.5.Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа 2015 оны ургац хураалтын урьдчилсан байдал болон байгаль цаг агаарын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр ургац алдсан талбайгаас хураан авсан ногоон тэжээл, улсын нөөцөд төлөх шатахууны өр, түүнийг төлөх боломжийн талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын улсын нөөцөөс Тариалан эрхлэлтийг дэмжих санд зээлээр авсан шатахууны үнэ болох 2.5 (хоёр тэрбум таван зуун сая) тэрбум төгрөгийн өрөнд 500 мянган боодол ногоон тэжээл нийлүүлэх асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгав. /СБТГ, ГТБХЗГ, МААБХЗГ/	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай байна.	70
31	2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 68 дугаар тэмдэглэл 2015-11-30 №: 68	37	XIX.6. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа 2015 оны ургац хураалтын дүнг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2016 оны тариалалтын бэлтгэлийг эртнээс хангаж, дутагдах хүнсний болон үрийн буудайг импортоор нийлүүлэх, гурилын хангамжийг тогтворжуулах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Болор нарт тус тус даалгав.	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай байна.	90

32	2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр 08 дугаар тэмдэглэл 2016-02-04 №:8	38	Ү. 2. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний фермер", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", Улсын тэргүүний тариаланч"-ийн шагналыг орон нутагт нь гардуулах Засгийн газрын гишүүд, бүрэлдэхүүнд нь орох төлөөллийг холбогдох албан тушаалтан болон орон нутгийн удирдлагатай зөвшилцөн хуваарь батлахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад, уг үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгав.	Хасах саналтай.	100
33	2016 оны 02 дугаар сарын 08-ны өдөр 09 дүгээр тэмдэглэл 2016-02-08 №:9	39	ҮИ. 2. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, түүнийг устгах талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан, малын халдварт өвчнийг мэдээлэх, малын эмч нарыг чадавхижуулах арга хэмжээний талаарх саналын хамт 2016 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Хасах саналтай байна.	90
34	2016 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 10 дугаар тэмдэглэл 2016-02-15- №:10	40	ХҮ.3. Мал эмнэлэг, үржлийн газрын даргыг сонгон шалгаруулж томилох хүртэл хугацаанд даргын үүргийг түр орлон гүйцэтгэчийг томилж, М.Галбадрахыг мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Хасах саналтай байна.	100
		41	ХХИИ.2. Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний жагсаалт баталсан Засгийн газрын 2015 оны 336, Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолуудын хэрэгжилтийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг энэ оны 3 дугаар сарын 7-ны дотор багтаан Худалдан авах ажиллагааны газарт баталгаажуулан хүргүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.	Хасах саналтай.	100
		42	ХХИИ.3. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн 2015 оны жилийн эцсийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. 1. Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу, шуурхай зохион байгуулах; 2. Үүрэг болгосон шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд "Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем" (www.unelgee.gov.mn)-д байршуулж, гарсан үр дүн, үр нөлөөг холбогдох зөвлөлийн хурлаар	Хасах саналтай.	100

			хэлэлцүүлэн бодитойгоор хяналт-шинжилгээ хийж үнэлэн тайлагнах; 3. 2015 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг, даалгаврыг биелүүлэх талаар онцгой анхаарч, хэрэгжсэн ажлыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д бүртгүүлж, хяналтаас хасуулах; 4. Хуульд заасан эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх. /ХШҮДАГ/		
35	2016 оны 03 дугаар сарын 7-ны өдөр 14 дугаар тэмдэглэл 2016-03-07 №: 14	43	ХҮ. 2016 оны тариалалтад дутагдах үрийн улаанбуудайн нөөц бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дотоод эх үүсвэрээс эргэн төвлөрүүлэх нөхцөлтэйгээр зохицуулалт хийж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	90
36	2016 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2016-03-21 № 17	44	ГҮ. 2. 2016 оны 4 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Болгар Улсын Софи хотод зохион байгуулах Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Болгарын Засгийн газар хоорондын комиссын 6 дугаар хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн баримтлах удирдамжийг хэлэлцэн зөвшөөрөв. 2. Уг хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд бөгөөд тус комиссын Монголын хэсгийн дарга Р.Бурмаад даалгав.	Хасах саналтай.	100
	2016 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 18 дугаар тэмдэглэл	45	ХИХ.3. “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилгод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгасан зорилт, арга хэмжээг 2015 онд хэрэгжүүлсэн явцын тухай “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасан зорилт, арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.		ХБ
37	2016-03-28 №: 18	46	ХИХ.4.2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав: 2.1. зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой заах; 2.2. үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний биелэлтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй нь уялдуулан тайлагнах.	Хасах саналтай	100
		47	ХИХ.5.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжилт нь удааширч байгаа зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.	Хасах саналтай байна.	90
38	2016 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2016-05-16 №: 28	48	ХХГҮ.4.1 Хаврын тариалалтад шаардлагатай импортоор оруулсан болон улсын нөөцөөс гаргаж байгаа үрийн улаанбуудайг тариаланчдад яаралтай олгож, үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалах ажлыг технологийн хугацаанд зохион байгуулж, 2016 оны төлөвлөсөн зорилтоо ханган биелүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Хасах саналтай байна.	100

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЛБАРТ ХОЛБОГДОХ ЭРХ ЗҮЙН АКТЫН ХЭРЭГЖИЛТ
/2016 он эхний хагас жилийн байдлаар/

/Хүснэгт-4/

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Зүйл, заалтын дугаар, агуулга	Хэрэгжилтийн явц, гарсан үр нөлөө	Тайлбар	Үнэлгээ
МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ					
1	Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай 2010 № 01	22.6 Улсын бүртгэлд эм, эмийн түүхий эд, биологийн идэвхт бүтээгдэхүүн бүртгэх, түргэвчилсэн журмаар бүртгэх, хугацаа, бүртгэлийн төлбөр тогтоох, зарцуулах журмыг эрүүл мэндийн болон хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	“Малын эмийн улсын бүртгэлийн дүрэм”-д ХХАА-н сайдын 2015 оны А-137 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулан батлуулж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн бүртгэлийн санд 307 дугаарт бүртгүүлэв. Малын эмийн салбар зөвлөлийн хуралдааныг 2016 оны хагас жилийн байдлаар 2 удаа зохион байгуулж улсын бүртгэлд бүртгүүлэхээр хүсэлт гаргасан эм ханган нийлүүлэх 28 байгууллагын дотоодын болон импортын 32 нэр төрлийн эмийг холбогдох баримт материалд үзлэг шинжилгээ хийж, шинээр улсын бүртгэлд бүртгэж, 6 эмийн бүртгэлийн хугацааг сунгаж хуралдааны шийдвэрийн хэрэгжилтийг хангаж ажиллав.		90
2	Хүнсний тухай 2012 № 21	16.2.Энэ хуулийн 16.1-д заасан баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг бүртгэх, нийтийн хэрэгцээнд гаргах журмыг хүнсний асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална. /ХҮБХЗГ/	“Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, бичил биетний цэвэр өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгэх” журмын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2015 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн А/110 дугаар тушаалаар батлуулан, ажлын хэсгийн уулзалтыг 4 удаа хийж, журмын төслийг боловсруулан, мэргэжлийн хяналтын байцаагчид, хүнс үйлдвэрлэгчдийн дунд хэлэлцүүлэг зохион байгуулав. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын зөвлөлийн 2015 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн хурлаар төслийг хэлэлцүүлж зөвлөлийн гишүүдээс гарсан саналыг тусган дахин хэлэлцүүлэхээр шийдвэрлэсэн. “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгэх журам боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх тухай зарыг 2016 оны 05 дугаар сарын 19-ны “Зуны мэдээ” сонинд хэвлүүлсний дагуу зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх мэдүүлгээ 3 байгууллагаас ирүүлсэн. Тендерийн үнэлгээний хорооны хурлаар хэлэлцүүлж хураангуй жагсаалтыг гаргав.		30
3.	Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай 2012 № 20	14.1. Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнд эрсдэлийн үнэлгээ хийх, тэдгээрийг бүртгэх журмыг эрүүл мэнд, хүнсний болон байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран батална.	ЭМСЯ, ХХААЯ болон БОАЖНХЯ- ны хамтарсан ажлын хэсэг байгуулагдаж, журмын төслийг боловсруулан хэд хэдэн удаагийн хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Нэгдсэн Үндэстний байгууллагын Хувиргасан амьд организмаас гаралтай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний платформд элсэн, үндэсний нарийн бичгээр ажиллаж байна.		30

4.	Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай 2015.11.26	7.5 Төрийн захиргааны төв байгууллага өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлалын хэрэгжилтийн явцад хоёр жил тутам хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, тайланг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлнэ. /ХШҮДАГ/	Хугацаа болоогүй.		ХБ
5.	Тариалангийн тухай /Шинэчилсэн найруулга/ 2016-01-29	15.8. Энэ хуулийн 15.7-д заасан газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох аргачлалыг тариалангийн болон байгаль орчны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Энэ хуулийн 15.7-д заасан “газрыг нөхөн сэргээх, хохирол тооцох аргачлал”-ыг боловсруулж байна.		30
		19.6. Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журмыг тариалангийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.	Тариалангийн үйлдвэрлэл эрхэлж байгаа иргэн, хуулийн этгээдийн үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнд мөнгөн урамшуулал олгох, мөнгөн бус дэмжлэг үзүүлэх журам”-ыг боловсруулж байна. ХХАА-н Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2016 оны төсөвт улаанбуудайн урамшуулалд 5,6 тэрбум төгрөгөөр баталж 610 иргэн, аж ахуйн нэгжид олгоод байна.		30
		21.1.Тариалангийн үйлдвэр-лэлийг хөгжүүлэх дунд хугацааны хөтөлбөрийг Засгийн газар батална.	“ Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах” богино хугацааны хөтөлбөр батлах тухай” Засгийн газрын 2016 оны 42 дугаар тогтоолоор баталсан.	Бүрэн хэрэгжсэн тул хасах саналтай.	100
		21.4.Тариалангийн бүтээгдэ-хүүний хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Тариалангийн бүтээгдэхүүний хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалыг боловсруулан ХХАА-н сайдын 2016 оны 05 дугаар сарын А-80 тоот тушаалаар баталж, Хууль зүйн яаманд бүртгүүлэхээр хүргүүлээд байна.		70
		23.4. Энэ хуулийн 23.1-д заасан мэдээ гаргах, хүргүүлэх болон энэ хуулийн 23.3-т заасан мэдээллийн сан бүрдүүлэх журмыг тариалангийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.	Хийгдээгүй байна.		0
		24.5. Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлалыг тариалангийн, хууль зүйн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална. /СБТГ/	“Тариалангийн талбайд мал, тэжээвэр амьтан орсны улмаас тариалангийн үйлдвэрлэл эрхлэгчид учруулсан хохирлыг тооцох аргачлал”-ыг боловсруулж байна.		30
ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ					
1.	“Нээлттэй хаалганы өдөр” зохион байгуулах тухай 2007-05-24 №:97	1 “БНМАУ-ын тусгаар тогтнолын талаархи асуудлын талаар бүх ард түмний саналыг гаргуулах тухай” БНМАУ-ын Бага хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны түүхэн шийдвэрийн дагуу Монгол Улсын тусгаар тогтнолыг баталгаажуулсан ард түмний санал асуулгыг явуулсан өдрийг тохиолдуулан	ХХААЯ-ны нээлттэй хаалганы өдрийг "Намрын ногоон өдрүүд" нэгдсэн арга хэмжээтэй хамтатган 2015 оны 9 дүгээр сарын 26-27-ны өдрүүдэд Чингисийн талбайд, 9 дүгээр сарын 29-ний өдрөөс 10 дугаар сарын 05-ны өдрүүдэд "Мишээл экспо" төвд зохион байгуулсан. Нэгдсэн арга хэмжээний хүрээнд хүнсний бүтээгдэхүүний "Монгол хүнс-органик хүнс", шинэ ургацын төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний "Алтан		90

		<p>Засгийн газар, орон нутгийн удирдлага, тэдгээрийн харьяаны бүх шатны байгууллага, албан тушаалтнууд бодлого боловсруулах, шийдвэр гаргахдаа иргэд, иргэний нийгмийн байгууллагуудын санал, зөвлөгөөг сонсч тусгах зорилгоор жил бүрийн 10 дугаар сарын 20-нд орон даяар “Нээлттэй хаалганы өдөр”-ийг зохион байгуулж ажиллахыг Засгийн газарт чиглэл болгосугай.</p>	<p>намар" үзэсгэлэн худалдаа, "Хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын улсын 2 дугаар зөвлөгөөн"-ийг тус тус зохион байгууллаа. Нээлтийн ёслолын ажиллагааны үеэр үндэсний хүнс үйлдвэрлэгч тэргүүлэгч үйлдвэрүүдийн 300 ажилтан, хоол үйлдвэрлэл үйлчилгээний салбарын 1400 тогоочдын хүндэтгэлийн парадыг зохион байгуулсан нь энэ жилийн онцлог байв.</p> <p>ХХААЯ-аас "Монгол хүнс-Органик хүнс" үзэсгэлэн худалдаанд хөдөө орон нутгаас ирж оролцсон хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч 128 аж ахуйн нэгж, хоршоо, иргэд, "Алтан намар" үзэсгэлэнд оролцсон 8 аймаг, нийслэлийн 5 дүүргийн нийт 250 ногоочин, 4 аж ахуйн нэгж, 12 хоршоо, 4 төслийн оролцогчдод үзэсгэлэнгийн талбайн түрээсийн төлбөрийг 100 хувь, "Монгол хүнс-Органик хүнс" үзэсгэлэн худалдаанд Улаанбаатар хотоос оролцсон 50 аж ахуйн нэгжид 80 хувиар хөнгөлж дэмжлэг үзүүллээ. Түүнчлэн хамтран ажилласан Нийслэлийн Мэргэжлийн хяналтын газрын төв лаборатори нь хүнсний аюулгүй байдлын явуулын лабораториор 150 гаруй аж ахуйн нэгж, хоршооны ургамлын гаралтай бүтээгдэхүүн, зөгийн бал зэрэг бүтээгдэхүүнд үнэ төлбөргүй шинжилгээ хийж, дүгнэлт гарган хяналт тавьж, бүтээгдэхүүний чанар аюулгүй байдал, хаяг шошгоны талаар зөвлөмж өгч ажиллалаа.</p>		
		<p>2 Бүтэн жилийн турш иргэдээс ирүүлсэн бүтээлч, ажил хэрэгч саналыг гүйцэтгэх удирдлагын байгууллагууд, холбогдох албан тушаалтан хүлээн авах, шийдвэрлэх, хэрэгжүүлэх, тэдгээрийн нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд үзүүлж байгаа эерэг үр дүн, үр нөлөөг нэгтгэн дүгнэж, ард түмэндээ мэдээлж байдаг эргэх холбооны тогтолцоог Засгийн газрын хэмжээнд бүрэлдүүлэн ажиллах нь зүйтэй гэж үзсүгэй. /ТЗУГ/</p>	<p>Иргэдийн санал хүсэлтийг бичгээр, цахимаар, утсаар, биечлэн, 11-11 төвөөр дамжуулан хүлээн авч шийдвэрлэж байна. 2016 оны эхний улирлын байдлаар тус яаманд нийт 154 санал хүсэлт ирснээс бичгээр 23, 11-11 төвөөр 101, цахимаар 29, биечлэн уулзсан ирж нэг хүн санал хүсэлт ирснийг тус тус шийдвэрлэж хариу өгсөн. Ирсэн нийт санал хүсэлтийн олонхи санал нь ноосны урамшууллыг хурдан олгохыг хүссэн санал байсан бөгөөд яамнаас дээрхи урамшууллыг олгуулах талаар удаа дараа Засгийн газар, Сангийн яаманд хүсэлт тавьж санхүүжилтийг шийдвэрлүүлж олгуулсан.</p> <p>Мөн малчдын санал хүсэлтийг үндэслэн тус яамны дэргэд малын хулгайн гэмт хэргийг бууруулах, урьдчилан сэргийлэх, алдсан болон олдсон малын мэдээллийг хүлээн авах, бүртгэх, хэвлэл мэдээллээр зарлах, малыг эзэнд нь олж өгөхөд туслах, цаг агаарын болон малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх талаархи мэдээллийг түгээх зорилготой “Малчдын лавлах- 109” төвийг ажиллуулж байна. 2016 оны 6 сарын 21-ний өдрийн байдлаар 971 малчин холбогдож 8000 малын зар өгч, 44 малчны 181 малыг олж өгөөд байна.</p> <p>Хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй гэрээ байгуулан алдсан олдсон малыг зарлуулж байна.</p>		70
2.	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Сүү, сүүн бүтээгдэхүүн,	1.1.Сүү, сүүн бүтээгдэхүүн, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх талаар дараах арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг чиглэл болгосугай. Эрчимжсэн мал аж ахуйн	Хүнс хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй хөтөлбөрүүдийн давхардлыг арилгаж хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор “Малын тэжээл”, “Экологийн цэвэр бүтээгдэхүүн”, “Сүү” хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, хөтөлбөрийн хүрээнд дэвшүүлсэн зорилт, арга хэмжээнд дүн	Хэрэгжилт тогтмолжсон	90

	<p>төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх тухай 2010.11.29 №250</p>	<p>хөгжлийг дэмжих хөтөлбөр”, “Малын тэжээл”, “Экологийн цэвэр бүтээгдэхүүн”, “Сүү” хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, нийслэл болон томоохон суурин газрын орчим сүүний чиглэлийн фермерийн аж ахуйг эрчимтэй хөгжүүлэхэд шаардагдах газар зохион байгуулалт, бэлчээрийн хуваарилалтыг шинэчлэн зохион байгуулах, сүүний фермерүүд хоршиж тэжээлийн ургамал тариалах, хадлан тэжээл бэлтгэж нөөцлөх, тэжээлийн болон даршны үйлдвэрлэлийг дэмжих, сүүний чиглэлийн үхрийн генефондыг сайжруулах, өсвөр үхрийг технологийн дагуу бойжуулах, сүү хүлээн авах, хадгалах, тээвэрлэх үеийн эрүүл ахуй, ариун цэврийн нөхцөлийг сайжруулах, хуурай сүүний үйлдвэр байгуулах, сүү нөөшлөх технологи нэвтрүүлэх, сүүний нөөц бүрдүүлэх зэрэг чиглэлээр хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;</p>	<p>шинжилгээ хийсэн дүнг үндэслэн зарим хөтөлбөрийг нэгтгэх, хүчингүй болгох талаар санал боловсруулж, Засгийн газарт танилцуулан дэмжигдэж Засгийн газрын 2011 оны дугаар 113 дугаар тогтоолоор “Малын тэжээл”, “Экологийн цэвэр бүтээгдэхүүн”, “Сүү” хөтөлбөрүүдийн “Хүнсний аюулгүй байдал” хөтөлбөрт давхцаагүй заалтыг нэмж тусган уг хөтөлбөрт нэгтгэн хэрэгжүүлэхээр шийдвэрлэсэн. Засгийн газрын 2011 оны 304 дүгээр тогтоолоор Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалтыг баталсан. Засгийн газрын 2013 оны 141 дүгээр тогтоолоор сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг цогц байдлаар нэмэгдүүлэх зорилгоор Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс 27.7 сая ам.долларын хөрөнгө оруулалтын зээлийг Голомт банкаар дамжуулан аж ахуйн нэгжүүдэд олгохоор шийдвэрлэсэн. Үүний дагуу “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл” төслийн хүрээнд Голомт банкнаас нийт 47 төсөлд 38.5 тэрбум төгрөгийн зээл батлагдаж 44 төсөлд 29.4 тэрбум төгрөгийн зээл олгосноос эрчимжсэн мал аж ахуйн 24 төсөлд 18.7 тэрбум, сүү боловсруулах 4 төсөлд 8.5 тэрбум, сүү боловсруулах цехийн 16 төсөлд 2.2 тэрбум төгрөгийн зээл олгоод байна. “ТЭСО” ХХК нь “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл” төслийн хүрээнд олгосон зээлийн санхүүжилтийн дэмжлэгээр хоногт 100 тн шингэн сүү боловсруулан 10 тн хуурай сүү үйлдвэрлэх үйлдвэрийг 2014 оны 10 сард ашиглалтанд оруулж, үйлдвэрээсээ 300 км-ийн радиуст байрлах сонгон авсан сумдад тус бүр 15 тонны хүчин чадалтай 8 хөргөлтийн төв, 20 тасгийг байгуулж, 5 тонны багтаамж бүхий 8 цистернээр сүүг үйлдвэртээ татан авч байна. Гаалийн статистик мэдээгээр 2013 онд 3959.2 тонн, 2014 онд 4104.7 тонн, 2015 онд 3137.1 тонн хуурай сүү импортолсон байна. Дээрх хуурай сүүний үйлдвэр ажиллаж эхэлсэнээр 2015 онд импортолсон хуурай сүүний хэмжээ өмнөх оныхоос 23.5 хувиар, 2013 оныхоос 20.8 хувиар тус тус буурсан. “Сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл” төслийн хүрээнд олгосон зээлийн санхүүжилтээр “Эн Жи Жи” ХХК- үнээний сүүний хөргөлтийн 10 цэг, гүүний сүүний 3 цэг, ингэний сүүний 4 цэг шинээр байгуулахаар бэлтгэж байна. “АПУ” ХХК нь хоногт 150 тонн шингэн сүү хүлээн авч боловсруулах хүчин чадал бүхий бүрэн автомат сүүний үйлдвэрийг 2014 оны 6 сард ашиглалтанд оруулж, орон нутагт сүүний хөргөлтийн 11 цэгийг байгуулан үйл ажиллагаагаа явуулж байна. Төв аймгийн Батсүмбэр сумын Үдлэг /1/, Борнуур сумын Нарт /1/ багуудад “Мон-Фреш” ХХК-ийн хөрөнгө оруулалтаар өдөрт 5 тн сүү хүлээн авах хүчин чадалтай, хөргөлтийн иж бүрэн систем бүхий, тус бүр нь 100 сая төгрөгний хөрөнгө оруулалттай сүүний хөргөлтийн төв 2013 онд ашиглалтад орсон.</p>	<p>тулхасах саналтай.</p>	
--	---	--	--	---------------------------	--

			<p>Сүүний нөөц бүрдүүлэх зорилгоор сүүний чиглэлийн үхрийн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн үйл ажиллагааг дэмжиж “Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих” хөтөлбөрийн хүрээнд 2012-2015 онд нийт 144 иргэн, аж ахуй нэгжид 2.5 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг Мал хамгаалах сангаар дамжуулан олгосон. Үүний дүнд 2015 оны жилийн эцсийн мэдээгээр сүүний үхрийн 1119 аж ахуйд 45218 толгой үхрийг өсгөн үржүүлж байгаа нь 2010 оныхоос үхрийн аж ахуйн тоо 470-аар, үхрийн тоо 2 дахин нэмэгдсэн байна.</p> <p>ХАА-д үйлдвэрлэсэн сүүний хэмжээ 2015 онд 874.4 мянган тоннд хүрсэн нь 2010 оны үзүүлэлтээс 2.4 дахин өсчээ. Сүүний чиглэлийн фермерийн аж ахуйнуудаас 2015 онд 105.18 мянган тонн сүү нийлүүлсэн нь 2010 оныхоос 3 дахин өссөн байна.</p> <p>Монголын Хүнсчдийн Холбоо, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн санаачилгаар ХХААЯ, төрийн бус байгууллагуудтай хамтран “Сүүтэй Монгол” үндэсний аяныг Монгол Улсын Ерөнхийлөгч Цахиагийн Элбэгдоржийн ивээл доор 2015 оны 02 дугаар сарын 16-нд эхлүүлсэн.</p> <p>Тэжээл үйлдвэрлэлийн хангамжийг сайжруулах зорилгоор 2013 онд хоногт 2-3 тонн тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай хүчит тэжээлийн 17 үйлдвэрийг 400.0 сая, ногоон тэжээлийн 15 үйлдвэрийг 500.0 сая, өвс хуйлж боох 45 техникийг 500.0 сая, нийт 1400.0 сая төгрөгийн худалдан авах ажлыг зохион байгуулан, иргэн, аж ахуй нэгжид олгов. ҮХАА-н сайдын 2013 оны А/100 дугаар тушаалаар Сэлэнгэ, Төв аймаг болон нийслэлийн ойролцоох эрчимжсэн мал аж ахуйд тэжээлийн үйлдвэрийн 5 иж бүрдлийг олгов. Хүчит тэжээлийн үйлдвэрүүд үйл ажиллагаа явуулснаар мал аж ахуйн салбарт бэлтгэсэн өвс, тэжээлийн 30-аас доошгүй хувийг үйлдвэрийн аргаар бэлтгэх боломжийг бүрдүүлсэн.</p> <p>ҮХАА-н сайдын 2014 оны төсвийн багцад малын тэжээл үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээнд зориулан 3.0 тэрбум төгрөг тусгагдсанаар Украин Улсаас нийт 695.6 сая төгрөгөөр 28 ширхэг өндөр нягтралтай өвс хаман боогч, БНХАУ-аас нийт 1.5 тэрбум төгрөгөөр тус бүр нь 40.0 сая төгрөгийн үнэтэй 80 морины хүчтэй трактор /ЛТ-850/, тус бүр нь 8.6 сая төгрөгийн үнэ бүхий өвсний хадуур /9SGJ-4.1/, тус бүр нь 4.7 сая төгрөгийн үнэ бүхий тармуур, 30 иж бүрдэл бүхий хадлангийн тоног төхөөрөмж, ОХУ-аас тус бүр нь 150.0 сая төгрөгийн үнэ бүхий нэг ба олон наст тэжээлийн ургамлын өндөр хүчин чадалтай 5 үрлүүрийг тус тус худалдан авч, орон нутагт нийлүүлсэн байна.</p> <p>Хадлангийн тоног төхөөрөмжийг орон нутагт олгосноор жил бүр 1000-1100 мянган тонн байгалийн хадлан, 3.1-7.9 мянган тонн сурэл, 36.6-46.7 мянган тонн гар тэжээл, 2.1-8.5 мянган тонн даршийг богино хугацаанд бэлтгэж байна.</p> <p>“Түмэн шувуут” ХХК-ийн цогцолбор аж ахуйд шинээр ашиглалтад оруулсан бүрэн автомат тэжээлийн үйлдвэр нь цагт 12 тонн малын тэжээл үйлдвэрлэх хүчин чадалтай бөгөөд түүхий эдийн хангамжийг сайжруулбал</p>		
--	--	--	--	--	--

		/микро элементүүдээс бусад/ дотоодын хэрэгцээт тахианы тэжээлийг бүрэн үйлдвэрлэх боломжтой.																																					
	<p>1.2.Төмс, хүнсний ногооны үйлдвэрлэлийн тогтвортой өсөлтийг хангах, хүнсний ногооны нэр төрлийг олшруулж, сортыг сайжруулах, усалгаатай тариаланг нэмэгдүүлэх, төмс, хүнсний ногоог боловсруулах, нөөшлөх үйлдвэрлэлийг өргөжүүлэх, агуулахын аж ахуйг хөгжүүлэх, үйлдвэрлэгчээс хэрэглэгчид шууд борлуулалт хийх орчинг бүрдүүлэн тэдний харилцан холбоог ойртуулах;</p>	<p>Манай улсад 2016 оны эхний хагас жилийн байдлаар хүнсний ногоо, жимс жимсгэнэ боловсруулж нөөшилдөг 78 үйлдвэр, цех ажиллаж байгаас хүнсний ногоо нөөшлөх, ногооны салат хийх 49, жимс, жимсгэнэ боловсруулах 24, кимчиний 17 үйлдвэр, цех байна.</p> <p>Монгол Улс, Швейцарийн хөгжлийн агентлаг хооронд хэрэгжүүлсэн буцалтгүй тусламжийн “Монгол төмс” хөтөлбөрийн хүрээнд Улаанбаатар хотод франц савханцрын 3 цех, чипсний 1 үйлдвэр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд тус цех нь өдөрт 200 кг франц савханцар үйлдвэрлэн томоохон хоолны газруудад нийлүүлж байна.</p> <p>Хүнсний ногоо боловсруулах чиглэлээр Дорнод аймагт 2, Ховд болон Орхон аймагт тус бүр 1 аж ахуйн нэгж нийт 4 аж ахуйн нэгж шинээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Орхон аймгийн Жаргалант суманд “Талын шүүдэр” ХХК нь БНХАУ-д үйлдвэрлэсэн цагт 150-200 кг төмс боловсруулах хүчин чадалтай хагас автомат бага оврын шарсан төмсний үйлдвэрийг ашиглалтанд оруулсан байна.</p> <p>“Дөрвөн өлзий” ХХК “Хүнсний ногоо боловсруулах цогц үйлдвэрлэл ба хүүхдийн тэжээлийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх” төслөөр 1.4 тэрбум төгрөгийн зээлэнд хамрагдан үйл ажиллагаа явуулж байна. Тус компани 2014 оноос алимны нухаш үйлдвэрлэх технологийг нэвтрүүлж “Алимхан хүүхдийн тэжээл” үйлдвэрлэн дотоодын хэрэгцээнд нийлүүлж эхэлсэн.</p> <p>2015 онд 12.7 мянган га-д төмс тарьж 165 мянган тонн ургац хураан авсан нь 2012 онтой харьцуулахад гангийн улмаас талбайн хэмжээ 3.5 мянган га-р, хураан авсан ургац 81.0 мянган тонноор буурсан дүнтэй байна.</p> <table border="1" data-bbox="1025 938 1877 1129"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2012</th> <th>2013</th> <th>2014</th> <th>2015</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Төмсний үйлдвэрлэл, тонн</td> <td>245935</td> <td>191619</td> <td>161489</td> <td>165273</td> </tr> <tr> <td>Төмсний хангамж, хувь</td> <td>219.8</td> <td>167.5</td> <td>138.2</td> <td>100.0</td> </tr> <tr> <td>Монгол төмс хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэсэн бичил булцуу, мянган ш</td> <td>131.4</td> <td>125</td> <td>112.0</td> <td>40.0</td> </tr> </tbody> </table> <p>2015 онд 6.8 мянган га-д хүнсний ногоо тарьж 72.7 мянган тонн ургац хураан авсан нь 2012 онтой харьцуулахад гангийн улмаас талбайн хэмжээ 0.4 мянган га-р, хураан авсан ургац 26.2 мянган тонноор буурсан дүнтэй байна.</p> <table border="1" data-bbox="1025 1257 1877 1417"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2012</th> <th>2013</th> <th>2014</th> <th>2015</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Хүнсний ногооны үйлдвэрлэл, тонн</td> <td>98918</td> <td>101762</td> <td>104792</td> <td>72741</td> </tr> <tr> <td>Хүнсний ногооны хангамж, хувь</td> <td>50.0</td> <td>52.0</td> <td>54.0</td> <td>44.0</td> </tr> </tbody> </table> <p>2015 оны байдлаар хүнсний ногооны үр үйлдвэрлэгч 21 иргэн, аж ахуйн нэгж таримал ургамлын үр үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй үйл</p>	Үзүүлэлт	2012	2013	2014	2015	Төмсний үйлдвэрлэл, тонн	245935	191619	161489	165273	Төмсний хангамж, хувь	219.8	167.5	138.2	100.0	Монгол төмс хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэсэн бичил булцуу, мянган ш	131.4	125	112.0	40.0	Үзүүлэлт	2012	2013	2014	2015	Хүнсний ногооны үйлдвэрлэл, тонн	98918	101762	104792	72741	Хүнсний ногооны хангамж, хувь	50.0	52.0	54.0	44.0	Хэрэгжилт тогтмолжсон тулхасах саналтай.	90
Үзүүлэлт	2012	2013	2014	2015																																			
Төмсний үйлдвэрлэл, тонн	245935	191619	161489	165273																																			
Төмсний хангамж, хувь	219.8	167.5	138.2	100.0																																			
Монгол төмс хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрлэсэн бичил булцуу, мянган ш	131.4	125	112.0	40.0																																			
Үзүүлэлт	2012	2013	2014	2015																																			
Хүнсний ногооны үйлдвэрлэл, тонн	98918	101762	104792	72741																																			
Хүнсний ногооны хангамж, хувь	50.0	52.0	54.0	44.0																																			

ажиллагаа явуулж, голлох хүнсний ногооны таримлын үрээр дотоодын хэрэгцээг 46.8 хувиар хангаж байна. Улсын сорт сорилтын зөвлөлийн хуралдаанаар хүнсний ногооны 6 сортыг ирээдүйтэй, 2 сортыг нутагшсан сортоор батлуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэв. Төл сонгины 7 тонн үрийг импортоор авч үр үржүүлээд байна.

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016*
Улсын төсвийн хөрөнгө оруулалт, сая төгрөг	45.5	146.0	120.0	80.0	120.0
Хүнсний ногооны үр үржүүлэх аж ахуйн нэгжийн тоо	12	17	19	21	
Ирээдүйтэй сорт	6	11	17	6	
Нутагшсан сорт	-	-	-	2	
Хүнсний ногооны үрийн хангамж, хувь	50.0	37.5	37.5	46.8	
Дотоодод үржүүлсэн үр, тонн	8.0	6.0	6.0	7.5	
Импортын үр, тонн	-	40.0	10.0	7.0	

2015 оны байдлаар төмсний албан бус үр үржүүлэгч 300 иргэн, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулж, төмсний үрээр дотоодын хэрэгцээг бүрэн хангаж байна. Улсын сорт сорилтын зөвлөлийн хуралдаанаар хүнсний ногооны 2 сортыг ирээдүйтэй сортоор батлуулж үйлдвэрлэлд нэвтрүүлэв.

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016*
Улсын төсвийн хөрөнгө оруулалт, сая төгрөг	60.0	-	-	-	80.0
Төмсний үр үржүүлэх аж ахуйн нэгжийн тоо	160	190	230	300	
Ирээдүйтэй сорт	3	2	1	2	
Нутагшсан сорт	3	3	-	-	
Төмсний үрийн хангамж, хувь	80	100	100	100	
Дотоодод үржүүлсэн үр, тонн	40.0	34.5	33.2	35.0	
Импортын үр, тонн	143.8	0.09	-	-	

2015 онд хүнсний ногоо боловсруулж нөөшилдөг 81, шарсан төмс, төмсний 9 үйлдвэр, жимсний 35 үйлдвэр үйл ажиллагаа явуулж байна.

Үзүүлэлт	Хүнсний үйлдвэр		
	Төмс	Хүнсний ногоо	Жимс
Хот	8	38	10
Орон нутаг	1	43	25
Нийт	9	81	35

“Дөрвөн өлзий” ХХК “Хүнсний ногоо боловсруулах цогц үйлдвэрлэл ба хүүхдийн тэжээлийн үйлдвэрлэлийг санхүүжүүлэх” төслөөр 1.4 тэрбум төгрөгийн зээлэнд хамрагдан үйл ажиллагаа явуулж байна.

Эдийн засгийн хөгжлийн яамнаас санаачилсан сумдад “Хүнсний ногоо боловсруулах 60 цех” байгуулах зургийн даалгаврыг “Архитектур нэгдэл” ХХК-иар гүйцэтгүүлсэн боловч хөрөнгийн асуудал шийдэгдээгүй. Мөн Чингис бондын 888 төсөлд “Актив групп” ХХК-ийн төмс боловсруулж, ангилан савлах, улмаар экспортод гаргах” төслийг дэмжин ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч дэмжигдээгүй.

2015 онд зоорины хүчин чадлыг 4000 тонноор нэмэгдүүлснээр нийт зоорины багтаамж 186000 тоннд хүрч, 2012 оноос 17000 тонн буюу 10 хувиар өссөн дүнтэй байна. Зоорины жилийн хэрэгцээ 350000 тонноос 2015 онд 53.1 хувийг хангаж байна.

Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016*
Төмс, хүнсний ногооны зоорины хүчин чадал, тонн	169000	173000	182000	186000	211000
Хангамж, хувь	-	49.4	52.0	53.1	60.0
Хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг		1.0	33.08		
Зоорины тоо	32	5	4	2	6
Тухайн онд байгуулсан зоорины хүчин чадал, тонн	20000	4000	9000	4000	25000

2015 онд усалгаатай талбайн хэмжээг 80 га талбайгаар нэмэгдүүлснээр нийт усалгаатай тариалан 54122 га-д хүрч, 2012 оноос 3222 га талбай буюу 6.3 хувиар өссөн дүнтэй байна. Зорилтот түвшингийн биелэлт 67.7 хувьтай байна.

Мөн инженерийн болон энгийн хийцтэй услалтын системийн ашиглалт, чанар байдлын судалгааг нарийвчлан гаргаж БОНХАЖЯ-аас хэрэгжүүлж байгаа усалгаатай тариалангийн мэдээ, услалтын мэдээг “Улсын усны мэдээллийн сан”-д оруулахаар санал хүргүүлээд байна.

Үзүүлэлт	2012	2013	2014	2015
Усалгаатай тариалан, га	50900	53368	54042	54122
Тухайн онд нэмэгдсэн усалгаатай тариалан, га	2468	1076	674	80
Услалтын системийн тоо	28	10	7	1
Улсын төсвийн хөрөнгө оруулалт, сая төгрөг	4600.0	5600.0	2800.0	127.0

Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнэ тогтворжуулах хөтөлбөрт хамрагдаж төслийн зээл авсан аж ахуйн нэгжүүдийг түшиглэн төмс, хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын логистик сүлжээний загвар менежмент бүтцийг бий болгох зөвлөх үйлчилгээний тендерийг зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулсан.

Төмс, хүнсний ногооны хадгалалт, борлуулалтын логистик сүлжээ

			<p>байгуулах ТХНЛС-2015-01/загвар менежмент зөвлөх үйлчилгээний тендерт Монголын хөдөөг шинэчлэх фермерүүдийн холбоо ТББ, Логистик сүлжээ байгуулахад оролцогч талуудын туршлага солилцох арга хэмжээ, гэрээний эрх зүйн зөвлөгөө өгөх ТХНЛС-2015-02/зөвлөмж зөвлөх үйлчилгээний тендерт Монголын логистикийн холбоо ТББ тус тус шалгарч гэрээ байгуулсан. Тендерийн гэрээнд санхүүжилтийн 40 хувийн урьдчилгаа авсан тохиолдолд ажлыг эхлүүлэх нөхцөл заасан. Санхүүжилтийн асуудал шийдвэрлэгдэж чадаагүй учир эдгээр ажлууд хийгдээгүй.</p> <p>Монгол банкны Ерөнхийлөгч, Үйлдвэр хөдөө аж ахуйн сайдын хамтарсан 2013 оны А/166/А-24 дугаартай тушаалаар баталсан “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногоо, мах, махан бүтээгдэхүүний зоорь, агуулах, худалдааны төв байгуулах төсөл сонгон шалгаруулан хөнгөлөлттэй зээл олгох ажлыг зохион байгуулсан. Төсөл сонгон шалгаруулж 31 аж ахуйн нэгжид 97,6 тэрбум төгрөгийн зээл олгосон. Үүнээс төмс, хүнсний ногооны агуулах зоорь байгуулах төсөл хэрэгжүүлж байгаа 12 аж ахуйн нэгжээс зургаа нь ажлаа хийж гүйцэтгэсэн. Ингэснээр төмс, хүнсний иогооны зоорь, агуулахын багтаамж 10,1 мянган тонноор нэмэгдэж байна. Төсөл бүрэн хэрэгжиж дуусахад зоорийн багтаамж 45.0 тонноор нэмэгдэх боломжтой.</p> <p>Төмс, хүнсний иогооны зоорь, агуулахыг түшиглэсэн хадгалалт борлуулалтын сүлжээ байгуулж, ногоочдын борлуулалтыг дэмжих ажлыг ирэх оноос хэрэгжүүлэхээр ажиллаж байна.</p>																																
		<p>1.4. “Чацаргана” хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлж, жимс, жимсгэнэ тариалах, боловсруулах жижиг дунд үйлдвэрийг дэмжин хөгжүүлэх /ХҮБХЗГ, ГТБХЗГ/</p>	<p>2015 онд жимс жимсгэнэ тариалсан талбайг 219 га-р нэмэгдүүлснээр нийт жимс жимсгэнэ тариалсан талбай 5859 га-д хүрч 2041 тонн жимс жимсгэнэ хураан авсан нь 2012 онтой харьцуулахад тариалсан талбай 4.4 дахин, хураан авсан ургац 2 дахин нэмэгдсэн байна.</p> <table border="1" data-bbox="1023 1018 1870 1385"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2012</th> <th>2013</th> <th>2014</th> <th>2015</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Жимс тарьсан талбай, га</td> <td>1317.3</td> <td>4904.5</td> <td>5640.0</td> <td>5859.0</td> </tr> <tr> <td>Хураасан жимс, тн</td> <td>1043.0</td> <td>1422.7</td> <td>1733.5</td> <td>2041.0</td> </tr> <tr> <td>Жимсний хангамж, хувь</td> <td>0.36</td> <td>0.48</td> <td>0.57</td> <td>0.67</td> </tr> <tr> <td>Олгосон суулгац, мян.ш</td> <td>765.9</td> <td colspan="3">770.0</td> </tr> <tr> <td>Чацарганы суулгацыг зээлээр авсан аж ахуйн нэгжийн тоо</td> <td>512</td> <td>182</td> <td>118</td> <td>60</td> </tr> </tbody> </table> <p>Хуурай бүс нутагт жилд 500 га талбайд жимс жимсгэнэ тариалах трактор, нүх гаргагч, хор цацагч, хог ургамал хадагчийн иж бүрдэл, 100 га талбай</p>	Үзүүлэлт	2012	2013	2014	2015	Жимс тарьсан талбай, га	1317.3	4904.5	5640.0	5859.0	Хураасан жимс, тн	1043.0	1422.7	1733.5	2041.0	Жимсний хангамж, хувь	0.36	0.48	0.57	0.67	Олгосон суулгац, мян.ш	765.9	770.0			Чацарганы суулгацыг зээлээр авсан аж ахуйн нэгжийн тоо	512	182	118	60	<p>Хэрэгжилт тогтмолжсон тулхасах саналтай.</p>	<p>90</p>
Үзүүлэлт	2012	2013	2014	2015																															
Жимс тарьсан талбай, га	1317.3	4904.5	5640.0	5859.0																															
Хураасан жимс, тн	1043.0	1422.7	1733.5	2041.0																															
Жимсний хангамж, хувь	0.36	0.48	0.57	0.67																															
Олгосон суулгац, мян.ш	765.9	770.0																																	
Чацарганы суулгацыг зээлээр авсан аж ахуйн нэгжийн тоо	512	182	118	60																															

			<p>усалгаажуулах дэвшилтэт дуслын усалгааны 20 иж бүрдэл систем нийлүүлж хөнгөлөлттэй нөхцлөөр олгов.</p> <p>Байгалийн чацарганы генетик нөөц тогтоох, шинэ сорт гаргах, чацаргана хураах, чацарганы нэмэгдсэн өртгийн сүлжээ байгуулах, шинж чанар найрлагыг тогтоох, газарзүйн заалттай бүтээгдэхүүнээр бүртгэлжүүлэх, судалгаа шинжилгээний ажлуудыг захиалгаар гүйцэтгүүлэв. Бүх аймаг, нийслэлд 5000 гаруй иргэн, аж ахуйн нэгжүүдэд жимс жимсгэнэ тариалах анхан, дунд шатны мэдлэг олгох сургалтууд зохион байгуулав. 300 тонны багтаамжтай 35 ш хөргөлттэй агуулах зээлээр олгож бүтээгдэхүүний хадгалалт, аюулгүй байдлыг дээшлүүлэв.</p> <p>Мөн жилд 2.5 сая ширхэг жимсний суулгац үржүүлж, 371 ногоон ажлын байр шинээр бий болгон 203.3 га талбайд элсний нүүдлээс хамгаалан, уул уурхайн нөхөн сэргээлт хийсэн ба 168 га байгалийн жимс жимсгэнийг нөхөн сэргээж, хамгаалсан байна. 2016 онд “Чацаргана” хөтөлбөрийн хүрээнд жимс жимсгэний талбайд усанд хэмнэлттэй 20 иж бүрдэл, тус бүр нь 6 га услах хүчин чадалтай дуслын усалгааны тендер шалгаруулалт зарлаад байна. Улаанбаатар хот, Хөвсгөл аймагт жимс боловсруулах, тариалах сургалт зохион байгуулж 100 иргэн, ААН-ийг хамруулав.</p>		
3.	Засгийн газарт чиглэл өгөх тухай 2013.06.10 № 88	Улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжигч төрийн байгууллага, түүнчлэн төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг олон нийтэд нээлттэй болгох ажлыг хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, иргэдэд ойлгомжтой, хүртээмжтэй байдлаар мэдээлэх “шилэн данс”-ны тогтолцоонд шилжих; /СБТГ/	Шилэн дансны тухай хууль батлагдсантай холбогдуулан http://www.mofa.gov.mn/new/ цахим хуудсанд “Шилэн данс” булан нээж тус яамны болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төв, орон нутгийн 28 байгууллагын мэдээллийг оруулж, төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг нийтэд нээлттэй болгох ажлыг хугацаанд нь зохион байгуулж ажилласан. Үндэсний аудитын газраас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн шалгалтад сайн үнэлгээ авсан.		70
		Төсвийн гүйцэтгэл, зарцуулалтад тавих иргэний хяналтын тогтолцоо хийгээд өнөөгийн эрх зүйн орчны талаар олон нийтэд сурталчлах, иргэдийн санал дүгнэлтийг хүлээн авсан эсэхийг эргэж мэдэгдэж байх тогтолцоог нэвтрүүлэх. /СБТГ/	Шилэн дансны тухай хууль батлагдсантай холбогдуулан http://www.mofa.gov.mn/new/ цахим хуудсанд “Шилэн данс” булан нээж тус яамны болон сайдын эрхлэх асуудлын хүрээний төв, орон нутгийн 28 байгууллагын мэдээллийг оруулж, төсвийн орлого, зарцуулалт болон тайлагналын үйл ажиллагааг нийтэд нээлттэй болгох ажлыг хугацаанд нь зохион байгуулж ажилласан. Үндэсний аудитын газраас шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн шалгалтад сайн үнэлгээ авсан.		70
УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ					
1	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг	3. хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн арилжаанд оролцох биржийн арилжааны зуучлагч /брокер/, хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдээс бүрдсэн хоршооны загвар бий болгох;	Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хуулийг хэрэгжүүлэх, малчид, иргэдийг орон нутгаас биржийн арилжаанд оролцох боломжоор хангах зорилгоор Өмнөговь аймгийн “Хотол таван эрдэнэ хоршоо”-той хамтран биржийн арилжааг 2016 оны 02 дугаар сарын 22-ны өдөр амжилттай зохион байгуулсан. Хөдөө аж ахуйн биржийн арилжаанд		50

	хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай 2011.02 № 29		оролцох боломжтой хоршоотой “Хөдөө аж ахуйн бирж” ХХК хамтран ажиллаж байна. Мөн “Жишиг хоршоо” төслийг эхлүүлээд байна.		
2.	Хүнсний тухай болон Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2012.12 № 67	1.3.стратегийн хүнс экспортлох, импортлох зөвшөөрлийн хураамж, түүний хэмжээг тогтооходтой холбогдсон Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаарх саналаа 2013 оны 01 дүгээр сард багтаан Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороонд ирүүлэх. /СБТГ/	Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар 2014 онд хэлэлцүүлсэн бөгөөд шаардлагагүй гэж түдгэлзүүлсэн болно.	Хасах саналтай байна.	100
3	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2015 онд баримтлах үндсэн чиглэл батлах тухай 2014.11.13 № 69	3.5.Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг зах зээлийн зарчимд шилжүүлэх замаар иргэдийн хэрэглээний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний нийлүү-лэлтийн тогтвортой тогтол-цоог бий болгож, хөтөлбөрөөс үе шаттай гарах арга замыг сонгож хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар, Монголбанк /Н.Золжаргал/-нд тус тус даалгасугай. /СБТГ, ХҮБХЗГ/	Монголбанк болон Засгийн газар хооронд 2012 оны 10 дугаар сарын 22-нд байгуулсан “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичгийн хүрээнд Монголбанкны ерөнхийлөгч болон ҮХАА-н сайдын хамтарсан 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн А-166/А/24 дугаар тушаалаар “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөрийг баталж, 3 бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд 3 жил хэрэгжүүлэхээр тусгасан. “Махны нөөц бүрдүүлэх үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийн хүрээнд 2013-2015 онд давхардсан тоогоор нийт 7 компанид 198.4 тэрбум төгрөгийн эргэлтийн хөрөнгийн зээл олгож, 40.5 мянган тонн махыг нөөцлөн худалдан борлуулсан. Хүн амын 2013 оны хэрэгцээнд зориулж УБ хотын жилийн нийт махны хэрэгцээний 15.4 хувийг бүрдүүлсэн бол 2014, 2015 онд 16.2 хувийг бүрдүүлсэн байна. Түүнчлэн 2013 онд бэлтгэсэн нөөцийг 100 хувь Монголбанк санхүүжүүлсэн бол 2014 онд 80 хувийг Монголбанк санхүүжүүлж, үлдсэн 20 хувийг банк өөрийн эх үүсвэрээр, 2015 онд 60 хувийг Монголбанк санхүүжүүлж, үлдсэн 40 хувийг банк өөрийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн. Хөтөлбөрийн хүрээнд агуулахын үлдэгдэл, хөдлөх хөрөнгийг барьцаалан зээл олгож, банк барьцааны зүйлд /агуулах дахь маханд/ тогтмол хяналт тавьж ажилласнаар зах зээлийн механизмд шинэ хэрэгсэл бүхий байнгын тогтолцоог бий болгов. “Гурилын үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд 2014-2015 онд нийт 57,8 тэрбум төгрөгийн зээлийг 14 гурилын үйлдвэрт олгосон. 2015	Хугацаан хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай	70

			<p>оны байдлаар хөтөлбөрт хамрагдсан үйлдвэрүүд нийт 17,9 тэрбум төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Засгийн газрын 2015 оны 8-р сарын 3-ны өдрийн 320 дугаар “Тэрээ сунгах тухай” тогтоолоор “Гурилын үнийг тогтворжуулах” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор 6 гурилын үйлдвэрт олгосон 17.9 тэрбум төгрөг зээлийн үлдэгдлийг стратегийн хүнсний нөөц бүрдүүлэх, үнэ тогтворжуулах нөхцөлтэйгээр сунгахаар шийдвэрлэсэн боловч эх үүсвэргүй тул хүлээгдэж байгаа болно.</p> <p>Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хүрээнд зээл олгохдоо хөдлөх хөрөнгө буюу гурилын үйлдвэрийн агуулах дахь буудай болон үйлдвэрлэсэн гурилыг барьцаалан арилжааны банкаар дамжуулан зээл олгосон. Хөтөлбөр дуусахад зээлийн үлдэгдэлтэй гурилын үйлдвэрүүд арилжааны зээлэнд шилжсэн бөгөөд барьцааны 50%-ийг хөдлөх хөрөнгөөр тооцож байгаа болно.</p> <p>Үндэсний аудитын газраас хөтөлбөрийн хэрэгжилтэд аудит хийсэн бөгөөд албан ёсны дүгнэлт гараагүй байна.</p>		
6.	<p>Эдийн засгийн хүндрэлээс гарах арга хэмжээний хөтөлбөр батлах тухай 2015-02-18 № 41</p>	<p>Хавсралт Монгол Улсын Их Хурлын 2015 оны 41 дүгээр тогтоолын хавсралт ЭДИЙН ЗАСГИЙН ХҮНДРЭЛЭЭС ГАРАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ХӨТӨЛБӨР</p> <p>Нэгдүгээр чиглэл. Макро эдийн засгийг тогтворжуулах Богино хугацаанд үр дүн гарах арга хэмжээ</p> <p>Д/д Зорилт Арга хэмжээ</p> <p>Хэрэгжүүлэх хугацаа Хариуцах этгээд Хүрэх үр дүн Харьцуулах суурь үзүүлэлт 2016 оны эцэст</p> <p>1. Төсвийн нэгдмэл, ил тод, хариуцлагатай бодлого хэрэгжүүлж, бизнесийг дэмжих</p> <p>1.1. Төсвийн нэгдмэл байдлыг хангах Газрын харилцааг боловсронгуй болгох</p> <p>Газрыг эдийн засгийн харилцаанд бүрэн оруулж, урт хугацаанд тогтвортой хөрөнгө оруулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Газрын тухай хуулийг шинэчлэн боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх 2015 оны 2 дугаар хагас жил Барилга, хот байгуулалтын яам Хууль батлагдаж хэрэгжиж эхэлсэн байна.</p>	<p>Засгийн газрын 2013 оны 141 дүгээр тогтоолоор “Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих” төсөлд 27.7 сая хүртэл “Хүлэмжийн аж ахуй байгуулах” төсөлд 17.4 сая ам долларын хөрөнгө оруулалтын зээлийг Засгийн газрын үнэт цаас арилжаалж бүрдүүлсэн хөрөнгөөс олгохоор шийдвэрлэсэн.</p> <p>“Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл” төслийн нэгжээс сонгон шалгаруулалтыг зохион байгуулж, сүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлээр Голомт банкнаас нийт 47 төсөлд нийт 38.5 тэрбум төгрөгийн зээл батлагдаж 44 төсөлд 29.4 тэрбум төгрөгийн зээл олгогдоод байна. Үүнээс эрчимжсэн мал аж ахуйн 24 төсөлд 18.7 тэрбум төгрөгийн зээл олгосон байна.</p> <p>Дээрх дэмжлэгийг олгосноор сүүний чиглэлийн үхрийн аж ахуй, түүнд өсгөн үржүүлж буй үхрийн тоо толгой жил бүр өссөн дүнтэй, улсын хэмжээнд 200-аас дээш сүүний чиглэлийн үхэртэй цогцолбор аж ахуй 15 байна.</p> <p>Дотоодод үйлдвэрлэсэн сүүний 57 хувийг үнээний сүү эзэлж байгаа бөгөөд үйлдвэрийн аргаар боловсруулсан сүү 2012 онд 53.2, 2013 онд 50.1, 2014 онд 71.7, 2015 онд 70,3* мянган тонныг тус тус боловсруулсан байна.</p> <p>“Хүлэмжийн аж ахуй байгуулах” төсөл сонгон шалгаруулалтад тэнцсэн 30 аж ахуйн нэгжид нийт 25.87 тэрбум төгрөгийн зээлийг олгосон. Төслийн үлдэгдэл санхүүжилтэд нээлттэй сонгон шалгаруулалтыг дахин зарлаж, тэнцсэн 3 байгууллага, аж ахуйн нэгжид нийт 658 сая төгрөгийн зээлийг олгож өвлийн хүлэмж 10,2 га хүлэмж байгуулж 3800 тонн хүнсний ногооны ургац нэмэгдсэн.</p> <p>Хүлэмжийн үйлдвэрлэл 2012 онд 86.2, 2013 онд 89.5, 2014 онд 104.9, 2015 онд 72.7 мянган тонн хүнсний ногоо хураан авсан ба энэ нь нийт ургацын 83.5 хувийг бүрдүүлсэн бөшөөд байнгын болон улирлын чанартайгаар 300 ажилын байр нэмэгдсэн.</p>		50

			<p>2016 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 185 дугаар тогтоолоор улаан лооль, ногоон сонгино, сонгины төрлийн бусад ногоо, бөөрөнхий байцаа, шар лууван, шар манжин, өргөст хэмх болон давжаа хэмх, төмс зэрэг таримлыг Дэлхийн худалдааны байгууллагатай тохирсон хэмжээнд буюу 20 хүртэл хувиар нэмэгдүүлсэн.</p> <p>Монгол Улсын Засгийн газрын 321 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах зорилгоор тус яамнаас "Мах" хөтөлбөрийг боловсруулан, хэрэгжүүлэх тухай Улсын Их Хурлын 2015 оны 108 дугаар тогтоолыг гаргуулан, Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 492 дугаар тогтоолоор "Мах хөтөлбөр"-ийг батлуулсан.</p> <p>"Мах" хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай ХХАА-н сайдын А-21 дүгээр тушаалаар үүрэг болгосны дагуу ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А-38 дугаар тушаалаар "Мах" хөтөлбөрт оролцох аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, нөөцийн махны бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт болон махны чанар, аюулгүй байдалд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна.</p>		
7.	Монгол Улсын 2014 оны төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015 он № 69	1.1.2014 оны төсвийн орлого, төсвийн тэнцэл, Засгийн газрын өр нь Төсвийн тогтвортой байдлын тухай, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2014 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2015-2016 оны төсвийн төсөөллийн тухай хуулиудыг зөрчсөнд дүгнэлт хийж, цаашид хуулийн хүрээнд үйл ажиллагаагаа явуулах /СБТГ/	Хүнс, хөдөө аж ахуйн Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсөв нь холбогдох хуулиудыг зөрчөөгүй болно.	Хасах саналтай байна.	100
8.	Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2016 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийг батлах тухай 2015 он № 52	5.2.2/Үндсэн чиглэлийн хэрэгжилтийн явцад тавих дотоодын байнгын хяналтыг сайжруулах, бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх Засгийн газрын байгууллагын чадавхыг сайжруулах арга хэмжээ авах /ХШҮДАГ/	Хугацаа болоогүй.		ХБ
9.	Хөдөө аж ахуйн "Халх гол" чөлөөт бүс байгуулах тухай 2015 он № 75	3.1."Халх гол" чөлөөт бүсэд дагаж мөрдөх технологийн болон амьтан, ургамлын хорио цээрийн журмыг батлан, хэрэгжилтийг зохион байгуулах; /СБТГ, Халх гол төсөл/	Хөдөө аж ахуйн Халх гол чөлөөт бүсэд дагаж мөрдөх технологийн болон амьтан, ургамлын хорио цээрийн журмыг ХХААЯ болон харьяа байгууллагын мэргэжилтэн, салбарын судлаач нар боловсруулж, Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн 60 дугаар тэмдэглэлээр Хүнс, хөдөө аж ахуйн сайдад үүрэг өгсний дагуу 2015 оны 11 дүгээр сарын 27-ны өдөр Төрийн ордонд нээлттэй хэлэлцүүлгийг 120 гаруй эрдэмтэд судлаачид, холбоод, орон нутгийн тариаланч, малчдын дунд зохион байгуулсан.	Хүчингүй болсон тул хасах саналтай байна.	50
		3.2."Халх гол" чөлөөт бүсэд хөдөө аж ахуйн	УИХ-ын 2015 оны 75 дугаар тогтоолыг 2016 оны 5 дугаар сарын 19-ний	Хүчингүй	-

		тогтвортой хөгжлийн загвар, шинжлэх ухаанд суурилсан байгаль орчинд ээлтэй дэвшилтэт технологи бүхий хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийг хөгжүүлэх;	өдрийн 46 дугаар тогтоолоор хүчингүйд тооцсон.	болсон тул хасах саналтай байна.	
10	Монгол Улсын 2016 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай 2015-12-03 №: 108	11.11/малчдын амьжиргааны түвшинг сайжруулах, махны зах зээл, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд "Мах" хөтөлбөрийг боловсруулан, Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Засгийн газрын 2015 оны 492 дугаар тогтоолоор “Мах хөтөлбөр”-ийг баталсан. Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2016 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 16 тоот тогтоолоор “Мах” хөтөлбөрийн хүрээнд дамжуулан олгох зээлийн хэмжээг нийт 100 тэрбум төгрөг байхаар баталсан. “Мах” хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухай ХХАА-н сайдын А/21 дүгээр тушаалаар үүрэг болгосны дагуу ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны А/38 дугаар тушаалаар “Мах” хөтөлбөрийн хүрээнд зээлийн дэмжлэг үзүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулах, гэрээ байгуулах, нөөцийн махны бүрдүүлэлт, хадгалалт, зарцуулалт болон махны чанар, аюулгүй байдалд хяналт тавих үүрэг бүхий ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Хөтөлбөрийн хүрээнд эхний ээлжинд Улаанбаатар, Дархан, Эрдэнэт хотын хүн амын 2016 оны 3-7 дугаар сарын хэрэгцээнд зориулан тогтвортой үнээр мах нийлүүлэх, “2016 оны 02 дугаар сарын 24-ний өдрөөс өмнө 500 тонноос багагүй хэмжээний махыг бэлтгэн зориулалтын хөргөлтэй агуулахад хадгалсан” 26 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулснаас нийт 5090 тн мах нөөцөлсөн 10 аж ахуйн нэгжид арилжааны банкны зээлийн хорооны хурлаас 25.0 тэрбум төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг олгохоор шийдвэрлэсэн.		90
		12 2/2016 оны хаврын тариалалтыг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тариалалтад зориулсан зээлийн эх үүсвэрийг холбогдох хуулийн хүрээнд Хөгжлийн банкнаас эргэн төлөгдөх нөхцөлтэйгөөр санхүүжүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах, буудай, төмс, гол нэрийн хүнсний ногооны хэрэгцээг дотоодын ургацаас хангах, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах, хөрсний үржил шимийг хамгаалах зорилгоор “Газар тариалангийн үйлдвэрлэлийг тогтворжуулах” богино хугацааны хөтөлбөрийг 2016 оны 01 дүгээр сарын 11-ны өдөр Засгийн газар баталлаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах 100 тэрбум төгрөгийн санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэж, газар тариалангийн үйлдвэрлэл эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжүүдэд хоёр жилийн хугацаатай зээл олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хөгжлийн банкны Төлөөлөн удирдах зөвлөлд зөвшөөрлөө. УИХ-ын шийдвэрийг хэрэгжүүлэх, 2016 оны тариалалтыг хэвийн явуулах боломжийг бүрдүүлэх зорилгоор эхний ээлжинд 2 жилийн хугацаатай, жилийн 12.5 хувийн хүүтэй 25.0 тэрбум төгрөгийн зээлийн эх үүсвэрийг Хөгжлийн банкаар шийдвэрлүүлж, улмаар ХААН, Голомт, Худалдаа хөгжил, Төрийн банкуудтай хамтран ажиллах санамж бичиг байгуулж дамжуулан зээлдүүлэх ажлыг эхлүүлэв. Өнөөдрийн байдлаар арилжааны 5 банкнаас нийтдээ 80 аж ахуйн нэгж, иргэнд 20.0 тэрбум төгрөгийн зээл олгохоор материалыг судлаж		90

		3 З/эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагаас бусад салбарын бүх шатны төрийн байгууллагын ажил үүргийг оновчтой хуваарилах, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, төрийн үйлчилгээний зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, үүнтэй холбогдуулан ажлын цагийг уян хатан тогтоож үр дүнг цагаар тооцох, сул орон тоонд нөхөн томилгоо хийхгүй байх зэргээр бүтээмжийг нэмэг-дүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг хэрэгжүүлэх замаар цалингийн зардлын 10 хүртэл хувьтай тэнцэх хэмжээний урсгал зардлын хэмнэлт бий болгох; /ТЗУГ/	Хөгжлийн банкинд хүргүүлж санхүүжилтийг шийдвэрлүүлээд байна			70
11	Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай 2016-02-05 №: 19	2/ Монгол Улсын Их Хурал болон Засгийн газраас баталсан үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг 2016 онд багтаан хянаж, шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулах;	Хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж буй үндэсний хэмжээний болон салбарын, салбар дундын хөгжлийн бодлого, хөтөлбөрүүдийг энэхүү үзэл баримтлалд нийцсэн эсэхийг хянаж, шинэчлэн боловсруулах арга хэмжээг хэрэгжүүлж байна.			10
УЛСЫН ИХ ХУРЛЫН БАЙНГЫН ХОРООНЫ ТОГТООЛ						
1.	Газар тариалангийн талаар авах зарим арга хэмжээний тухай 2012 № 02	1.1. Газар тариалангийн бүтээгдэхүүний чанарын үзүүлэлтийг дээшлүүлэх урамшууллын оновч-той хөшүүргийг бий болгох;	Алслагдсан бүсэд буудайн үйлдвэрлэл эрхэлж буй аж ахуйн нэгжүүдийг дэмжих, буудайн тариаланг нэмэгдүүлэх зорилгоор “Улаанбуудайн урамшууллыг бүсийн ялгавартайгаар олгох журам”-ын төслийг боловсруулан Засгийн газрын 2013 оны 11 дүгээр сарын 9-ний өдрийн хуралданаар хэлэлцүүлэн 366 дугаар тогтоолоор батлуулав. 2016 оны төсөвт Буудайн урамшуулалд 5.6 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд урамшуулалыг мөнгөн хэлбэрээр олгохоос татгалзаж арилжааны банкаар дамжуулан хүүгийн хөнгөлөлттэй зээл олгох, зээлийн хүүгийн хөнгөлөлтөд батлагдсан 5.6 тэрбум төгрөгийг шилжүүлэн олгохоор тогтоолын төсөл боловсруулан ЗГХЭГ-т хүргүүлсэн боловч шийдвэрлэгдээгүй. Тиймээс 2015 оны мөнгөн урамшуулалыг гурил үйлдвэрлэлд нийлүүлсэн буудайн тонн тутамд нь 50.0 мянган төгрөгөөр тооцож олгосон. Цаашдаа шинээр батлагдсан Тариалангийн тухай хуульд нийцүүлэн дэвшилтэд техник, технологи нэвтрүүлсэн, хөрсний үржил шимийг сайжруулах арга хэмжээний биелэлттэй холбогдуулан мөнгөн болон мөнгөн бус дэмжлэг үзүүлэх чиглэлээр асуудал боловсруулахаар төлөвлөж байна.			70
		1.2. Органик газар тариаланг хөгжүүлэх төрийн бодлогын чиглэлүүдийг тодорхойлж, түүнд дэмжлэг үзүүлэх механизмыг боловсруулах	Тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/85 тоот тушаалаар Тариалан эрхлэлтийг дэмжих санг хувийн хэвшлийн оролцоо бүхий корпораци болгон зохион байгуулах, эрх зүйн			70

		/СБТГ, ГТБХЗГ/	<p>орчинг бүрдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан. Сангийн яамнаас “Засгийн газрын тусгай сангийн тухай” шинэчлэн найруулж буй хуулийн төсөлд саналаа тусгаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнээр “Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн төсөлд Засгийн газрын тусгай сан - “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-г компанийн хэлбэрт шилжүүлж, компанийн 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хүртэлх хувийг үе шаттайгаар хувьчлахаар тусгасан бөгөөд Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 7-ний өдрийн хуралдаанаар Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжсэн тэмдэглэл гаргав.</p> <p>Улсын Их Хурлын 2016 оны 04 дүгээр сарын 07-ны өдрийн нэгдсэн хуралдаанаар “Органик хүнсний тухай” хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийж, хуралдаанд оролцсон гишүүдийн 75,8 хувийн саналаар дэмжсэнээр батлагдсан ба 2017 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөнө. Энэ хуулиар органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх, органик хүнс, тэжээл, бордоо үйлдвэрлэх, тэдгээрийг баталгаажуулах, худалдах, импортлох, органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээ хэрэглэх, сурталчлахтай холбогдсон харилцааг зохицуулна.</p> <p>Түүнчлэн органик хөдөө аж ахуйн үйлдвэрлэл эрхлэх болон хүнс үйлдвэрлэхэд тавигдах шаардлага, хэрэглэх бодис, органик орц найрлагыг тооцох, хамтын баталгаажуулалтын талаарх журам, жагсаалт, аргачлалыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж, мөрдүүлэх эрхийг хүнс, хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд олгохоор хуульчилсан.</p> <p>“Хүнсний тухай” хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт дурдсан төрөөс дэмжлэг, урамшуулал үзүүлж болох хүнсний чиглэлийн үйл ажиллагаанд органик хүнсний үйлдвэрлэл багтсан.</p>		
		1.3. Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн үйл ажиллагааг ил тод нээлттэй зарчмаар төр, хувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд ажиллуулж, хөндлөнгийн хяналтыг бий болгох; /СБТГ, ГТБХЗГ/	<p>ХХААЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2012 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/85 тоот тушаалаар Тариалан эрхлэлтийг дэмжих санг хувийн хэвшлийн оролцоо бүхий корпораци болгон зохион байгуулах, эрх зүйн орчинг бүрдүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулан ажилласан. Сангийн яамнаас “Засгийн газрын тусгай сангийн тухай” шинэчлэн найруулж буй хуулийн төсөлд саналаа тусгаж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэнээр “Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэл”-ийн төсөлд Засгийн газрын тусгай сан - “Тариалан эрхлэлтийг дэмжих сан”-г компанийн хэлбэрт шилжүүлж, компанийн 34-өөс доошгүй хувийг төрийн эзэмшилд байлгаж, 66 хүртэлх хувийг үе шаттайгаар хувьчлахаар тусгасан бөгөөд Засгийн газрын 2014 оны 6 дугаар сарын 7-ны өдрийн хуралдаанаар Төрийн өмчийг 2014-2016 онд хувьчлах УИХ-ын тогтоолын төслийг хэлэлцэн дэмжсэн тэмдэглэл гаргав.</p>		70

		<p>2.1. Дотоодын хэрэгцээнээс илүү гарсан улаан буудай, хивэг, тосны ургамлыг бололцоотой бүх хилийн боомтуудаар экспортлох боломжийг судалж шийдвэрлэх. Үүнтэй холбог--дуулан үндэсний үйлдвэрлэлээ хамгаалах үүднээс үр тариа, гурилын импортын гаалийн албан татварын хувь хэмжээг уян хатан байлгах асуудлыг Гаалийн тарифын зөвлөлтэй хамтран боловсруулж, санал оруулах; /СБТГ/</p>	<p>Монгол Улсаас БНХАУ-д улаанбуудай, арвай, хивэг экспортлох ажлын хүрээнд тус улсаас 2012 оны 10 дугаар сард арвайн эрсдэлийн үнэлгээний баг Улаанбаатар хот, Дорнод аймагт, хивэгийн эрсдэлийн үнэлгээний баг 12 дугаар сард Улаанбаатар хот, Дархан, Сэлэнгэ аймгуудад холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран ажилласан.</p> <p>Үр тарианы импортын гаалийн албан татварын хувь хэмжээг уян хатан байлгах асуудлыг судалж, УИХ-ын 1999 оны “Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” 27 дугаар тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тогтоолын төслийг УИХ-д өргөн барьсан. Уг тогтоолын төслийг 2013 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 01/1439 тоотой Төсвийн байнгын хороонд хүргүүлсэн. Уг асуудлыг намрын ургац хураалтын дараа шийдвэрлүүлэхээр түр хойшлуулсан боловч ургац хураалтын үр дүнгээр хүнсний улаан буудайг экспортод гаргах боломжгүй болсон.</p> <p>Монгол Улсын хууль тогтоомжийг 2016 он хүртэл боловсронгуй болгох “Үндсэн чиглэл”-ийн төсөлд тогтоолын төслийг оруулахаар саналаа тусгасан.</p> <p>Халх голын бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагаа, экспорт, импортыг дэмжих зорилгоор Өвдөг баян хошууны боомтыг байнгын ажиллагаатай болгох шийдвэрийг гаргуулав.</p>		70																									
		<p>2.2. Чанар сайтай хүнсний буудайн хүрэлцэхүйц нөөц бүрдүүлэх ажлыг зохион байгуулж, стандартын шаардлага хангасан элеватор, агуулахад хадгалах, хадгалалтын явцад хяналт тавьж ажиллах; /СБТГ, ГТБХЗГ/</p>	<p>Улсын хэмжээнд 538.0 мянган тоннын багтаамжтай 19 элеватор байна. Үүнээс Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн 182.0 мянган тонн, гурилын үйлдвэрүүдийн 276.5 мянган тонн, тариалан эрхлэгч аж ахуйн нэгжийн 80,0 мянган тонн багтаамжтай элеватор байна. Жил бүр элеваторуудад агуулахын ариутгал халдваргүйжүүлэлтийг мэргэжлийн байгууллагуудаар гүйцэтгүүлж, агуулахын засварыг бүрэн дуусгаж нөөцийн буудайг хүлээн авахад бэлэн болгож байна. Хүнсний буудайн хадгалалтын явцад Мэргэжлийн хяналтын ерөнхий газар улирал тутамд хяналт тавьж, дүгнэлт гарган ажиллаж байна.</p> <p>2015 оны ургацаас ТЭДС-д 6.5 мянган тонн үрийн буудай, 5.3 мянган тонн хүнсний буудай, нийтдээ 11.8 мянган тонн буудайн нөөц бүрдүүлэв.</p> <table border="1" data-bbox="1021 1078 1883 1331"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2012</th> <th>2013</th> <th>2014</th> <th>2015</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Улаанбуудай хадгалах элеваторын хүчин чадал, тонн</td> <td>111000</td> <td>147000</td> <td>182000</td> <td>182000</td> </tr> <tr> <td>Элеваторын тоо</td> <td>18</td> <td>19</td> <td>21</td> <td>22</td> </tr> <tr> <td>Хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг</td> <td></td> <td>4.6</td> <td>15.9</td> <td></td> </tr> <tr> <td>Тухайн онд байгуулсан элеваторын хүчин чадал, тонн</td> <td>-</td> <td>36000</td> <td>-</td> <td>36000</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2012	2013	2014	2015	Улаанбуудай хадгалах элеваторын хүчин чадал, тонн	111000	147000	182000	182000	Элеваторын тоо	18	19	21	22	Хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг		4.6	15.9		Тухайн онд байгуулсан элеваторын хүчин чадал, тонн	-	36000	-	36000		90
Үзүүлэлт	2012	2013	2014	2015																										
Улаанбуудай хадгалах элеваторын хүчин чадал, тонн	111000	147000	182000	182000																										
Элеваторын тоо	18	19	21	22																										
Хөрөнгө оруулалт, тэрбум төгрөг		4.6	15.9																											
Тухайн онд байгуулсан элеваторын хүчин чадал, тонн	-	36000	-	36000																										

2.	Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн чадавхийг бэхжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2015 он №7	1. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагааг дэмжих, статусыг тодорхой болгох, нутгийн өөрөө удирдах болон засаг захиргааны байгуул-лагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэх, хариуцан хамгаалж буй нутаг дэвсгэрийнхээ байгалийн нөөцийг давуу эрхтэйгээр ашиглах, байгаль хамгаалахад зарцуулсан зардлыг байгалийн нөөцийн төлбөрийн орлогоос буцаан олгох замаар нөхөрлөлийн санхүүгийн тогтвортой механизмыг бий болгох чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх асуудлыг судалж, зохих арга хэмжээ авах	Хөдөө аж ахуйн салбарын 2016-2017 оны өвөлжилтийн бэлтгэл хангах Засгийн газрын 322 дугаар тогтоолд аймаг, сумын Засаг дарга нарт зарим шаардлагатай хадлангийн талбайг өнжөөх, сэлгэх, өөр аймгийн нутагт хадлан бэлтгэх гэрээ, хэлэлцээр хийж зохицуулах арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.		50
		3. Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн үйл ажиллагаанд олон улсын туршлага, арга зүйд үндэслэсэн байгаль орчинд ээлтэй дэвшилтэт арга технологи, менежментийг нэвтрүүлэх, шаардлагатай бага оврын тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангахад чиглэсэн санхүүгийн дэмжлэг, хөнгөлөлт үзүүлэх төсөл, хөтөлбөрийг холбогдох байгууллагатай хамтран хэрэгжүүлэх	Тайлант 2016 онд бага оврын 1036 тракторыг 5 жилийн хугацаатай хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон байна.		50
ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ					
1	Ажлын хэсэг байгуулах тухай 2015-10-30 №: 213	2 Мал болон махан бүтээгдэхүүнийг БНХАУ-д экспортлоход бүх талын дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулж, явц, үр дүнг танилцуулж байхыг ажлын хэсэг (Д.Батцогт)-т даалгасугай	МХЕГ-ын дарга Ажлын хэсгийн нарийн бичгийн дарга болно.	Хамаарал гүй тул хасах саналтай байна.	-
ҮАБЗ-ИЙН ЗӨВЛӨМЖ					
1.	Малын эрүүл мэндийн өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний тухай 2011 23/20	1. Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, шинжээчдийн дүгнэлтийг харгалзан Мал, эмнэлгийн албаны үндэсний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх, бодлого, хяналт, үйлчилгээг мэргэжлийн удирдлага, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, удирдлагатай байхаар зохион байгуулах, /МААБХЗГ, МЭҮГ/	Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, шинжээчдийн дүгнэлтийг харгалзан Мал, эмнэлгийн албаны үндэсний тогтолцоог олон улсын жишигт нийцүүлэн өөрчлөх, бодлого, хяналт, үйлчилгээг мэргэжлийн удирдлага, мэдээллийн нэгдсэн тогтолцоо, удирдлагатай байхаар тооцон “Малын эрүүл мэндийн тухай” хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, эхний хэлэлцүүлгийг 2015 оны 05 дугаар сарын 19-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар хийлгэсэн. Энэ хуулийн төсөлд Дэлхийн мал, амьтны эрүүл мэндийн байгууллагын зөвлөмж, шинжээчдийн дүгнэлтээс зарим хэсэгт тусгагдсан.		30
		3. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, эрт сэрэмжлүүлэх, хариу авах арга хэмжээний бэлэн байдлын чадавхийг бэхжүүлэх зорилгоор Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газрын дэргэд шүлхийн вакцин,	Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Мал эмнэлэг, үржлийн газрын одоогийн бүтэц орон тоонд багтаан шуурхай нэгж байгуулахаар төлөвлөж, шаардлагатай техник хэрэгсэл (ширээ, сандал, компьютер, хувилагч машин) авахаар хязгаарлагдмал тендерийг 2016 оны 05 дугаар сард зарласан. Тендерт нийцсэн санал ирээгүй тул шууд худалдан авалт хийх		50

		<p>оношлуур, ариутгал халдваргүйтлийн бэлдмэл, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, дуудлагын машин бүхий шуурхай ажлын нэгж байгуулах, /МААБХЗГ, МЭҮГ/</p> <p>4.Сум, багийн мал эмнэлгийн үйлчилгээний анхан шатны хувийн нэгжүүдийн материаллаг баазыг бэхжүүлэх, малын үзлэг, шинжилгээний хашаа, угаалгын тоног төхөөрөмж, оношлогоо, шинжилгээний лаборатори, эм, биобэлдмэл, вакцин хадгалах зориулалтын агуулахаар хангах, /МААБХЗГ, МЭҮГ/</p> <p>5.Малын эмч, мал зүйч, зоотехникч нарыг хөдөлмөрийн хүнд, хортой, халдвартай нөхцөлд хамруулах асуудлыг судлан шийдвэрлэх, /МААБХЗГ, МЭҮГ</p>	<p>гэрээ байгуулах ажлыг зохион байгуулах комиссыг ЗГХА МЭҮГ-ын 2016 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн тушаалаар байгуулсан. Ажлын хэсэг шууд гэрээ байгуулах компанийг сонгох, хэлцэл хийхээр бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>2011 онд 20 аймгийн 75 МЭҮН-ийн үйл ажиллагааг хөнгөлөлттэй зээлээр дэмжиж, зөөврийн хөргүүр, температур, чийг хэмжигч, зүүгүй тариур, өвөл зуны нормын хувцас зэргээр 2.4 тэрбум төгрөгийн, 2012 онд лабораторийн оношлогооны багц, мэс заслын болон гоц халдварт өвчний үед хэрэглэгдэх иж бүрэн цомог, малын эмчийн дуудлагын багц зэргээр 2.6 тэрбум төгрөгийн, 2013 онд 10 аймгийн 110 суманд мал угаалгын төхөөрөмж 39, зөөврийн хашааны 96 иж бүрдлээр 2.6 тэрбум төгрөгийн, 2014 онд 12 аймгийн 68 суманд мал угаалгын 68 төхөөрөмжөөр 2.9 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийсэн.</p> <p>НХХЯ-нд удаа дараа санал хүргүүлж, НХХ-ийн сайдын “Тэтгэврийг хөнгөлөлттэй тогтоох газрын дор болон хөдөлмөрийн хортой, хүнд нөхцөлд хамаарах ажил, мэргэжлийн жагсаалтыг шинэчлэн батлах тухай” 2004 оны 77 дугаар тушаалаар батлагдсан жагсаалтын 2.15-д “Хөдөө аж ахуйн малын их, бага эмч, санитарч, трактор, комбайнч” (1995 оноос өмнөх) хөнгөлөлттэй нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгож байсан заалтыг ХАХНХ-ын сайдын 2104.11.03-ны өдрийн А/113 тушаалаар (1995 оноос өмнөх хамаарна) гэснийг хасч, дээрх албан тушаалтан он харгалзахгүйгээр хортой нөхцөлөөр тэтгэвэр тогтоолгох нөхцөл бүрдсэн. Малаас хүнд халдварладаг бруцеллөз өвчнийг малын эмч нарын мэргэжлийн өвчний жагсаалтад оруулахаар Хөдөлмөрийн яамны харьяа “Хөдөлмөрийн эрүүл мэнд судлалын төв”-тэй гэрээ байгуулан, дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна.</p>			50
		6.Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн техник, технологийг шинэчлэх, шинжилгээний болон халдвар хамгаалал, биоаюулгүй байдлын чадавхийг сайжруулах, /МААБХЗГ, МЭҮГ, МЭЭСБЛ/	Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн техник, технологийг шинэчлэх, шинжилгээний болон халдвар хамгаалал, биоаюулгүй байдлын чадавхийг сайжруулах чиглэлээр арга хэмжээ авч хэрэгжүүлээгүй болно.			0
2.	"Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2012 19/12	1.Хөдөө аж ахуй, хүнсний үйлдвэрийн хоршсон цогцолборыг бий болгоход чиглэсэн хөрөнгө оруулалт, санхүүгийн дэмжлэгийг нэмэгдүүлэх; /ХҮБХЗГ/	ШУТИС-ийн Хүнсний инженер, биотехнологийн сургуулийн дэргэд улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв” байгуулагдан орчин үеийн өндөр үзүүлэлттэй лабораторийн тоног төхөөрөмжөөр, өндөр ур чадвартай боловсон хүчнээр хангагдан итгэмжлэлд хамрагдахаар ажиллаж байна. Үйлдвэр, Хөдөө аж ахуйн яам, БНСУ-ын Олон улсын Хамтын Ажиллагааны байгууллага /KOICA/ хоорондын хамтын ажиллагааны хүрээнд “Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын лабораторийн чадавхийг бэхжүүлэх” төслийг /нийт санхүүжилт 1 сая ам.доллар/ Хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн “Само” институтэд 2013 оноос хэрэгжүүлж хүнсний нэгдсэн лабораторид өргөтгөл			90

			хийн 2014 оны 6 сард ашиглалтад оруулсан. Хүнсний салбарт ХХААЯ-ны захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төсөлд ШУТ-ийн сангаас 2012 онд 3 төсөлд 174.2 сая, 2014 онд 1 төсөлд 47.8 сая төгрөг, 2015 онд 1 төсөлд 115.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба 2016 оноос 2 төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.		
		3.Инженерийн хийцтэй худаг, услалтын систем, цас, борооны усыг хуримтлуулах цөөрөм, усан санг шинээр барих, сэргээн засварлах ажлыг эрчимжүүлэх, хөдөөгийн хүн ам, мал аж ахуй, газар тариалангын усан хангамжийг нэмэгдүүлэх; /МААБХЗГ/	2016 онд хөдөөгийн хүн ам мал аж ахуйн усан хангамжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд улсын төсөвт хөрөнгө тусгагдаагүй болно. Харин орон нутгийн өөрийн хөрөнгө оруулалтаар улсын хэмжээнд 100 гаруй инженерийн хийцтэй худаг шинээр барих болон сэргээн засварлахаар төсөвтөө тусгасан бөгөөд одоогийн байдлаар тендер шалгаруулалт болон гэрээ байгуулах ажил хийгдэж байна. Зах зээл ба бэлчээрийн удирдлагын хөгжлийн төслийн хүрээнд Архангай, Булган, Хөвсгөл, Говь-Алтай аймагт нийт 390,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар шинэ худаг 2, засварын худаг 14, хөв цөөрөм 2 шинээр барьж байгуулахаар гүйцэтгэгч аж ахуйн нэгжүүдтэй гэрээ байгуулаад байна.		70
		5.Хүн амын дунд зонхилон тохиолдож буй хоол тэжээлийн дутлыг бууруулахад чиглэсэн баяжуулсан болон зохицуулах үйлчилгээтэй хүнсний бүтээгдэхүүний үйлдвэр, эмчилгээ сувиллын газар, бага насны хүүхдийн нэмэгдэл хоолны үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх; /ХҮБХЗГ/	ЭМСЯ-наас санаачилсан “Нялх балчир насны хүүхдийн хоол ундны бүтээгдэхүүний тухай” хуулийн төсөл болон, “Эх хүүхдийн хоол тэжээлийн үндэсний стратеги”-ийн төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллан эдгээр төслийг боловсруулсан. Уг хуулийн болон стратегийн төсөлд баган насны хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах, үйлдвэрлэлд дэмжлэг үзүүлэх талаар хэд хэдэн заалт тусгагдсан. “Баяжуулагч бэлдмэл, хүнсний нэмэлт, өсгөврийн хөрөнгө, органик болон шинэ технологиор үйлдвэрлэсэн хүнсийг улсын бүртгэлд бүртгэх журам боловсруулах” зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх тухай зарыг 2016 оны 05-р сарын 19-ны “Зуны мэдээ” сонинд хэвлүүлсний дагуу зөвлөх үйлчилгээний ажил гүйцэтгэх мэдүүлгээ 3 байгууллагаас ирүүлсэн. Тендерийн үнэлгээний хорооны хурлаар хэлэлцүүлж хураангуй жагсаалтыг гаргав. “Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай” хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийг ҮХААЯ-ны ТНБД-ын 2014 оны А/170 дугаар тушаалаар байгуулан ажиллаж байна.		30
		6.Хүний эрүүл мэндийг дэмжих, импортын орлох, экспортын шинэ нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүнийг бий болгоход чиглэсэн эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг өргөжүүлэх, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа эрдэм шинжилгээ, сургалт, судалгааны байгууллагын чадавхийг бэхжүүлэх арга хэмжээ авах; /СБТГ, ХҮБХЗГ/	ШУТИС-ийн Хүнсний инженер, биотехнологийн сургуулийн дэргэд улсын төсвийн 4.3 тэрбум төгрөгийн хөрөнгөөр “Хүнс судлалын эрдэм шинжилгээний төв” байгуулагдан орчин үеийн өндөр үзүүлэлттэй лабораторийн тоног төхөөрөмжөөр, өндөр ур чадвартай боловсон хүчнээр хангагдан итгэмжлэлд хамрагдахаар ажиллаж байна. Үйлдвэр, Хөдөө аж ахуйн яам, БНСУ-ын Олон улсын Хамтын Ажиллагааны байгууллага /KOICA/ хоорондын хамтын ажиллагааны хүрээнд “Малын гаралтай хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлын хяналтын лабораторийн чадавхийг бэхжүүлэх” төслийг /нийт санхүүжилт 1 сая ам.доллар/ Хүнсний эрдэм шинжилгээ, үйлдвэрлэлийн “Само” институтэд 2013 оноос хэрэгжүүлж хүнсний нэгдсэн лабораторид өргөтгөл		90

			хийн 2014 оны 6 сард ашиглалтад оруулсан. Хүнсний салбарт ХХААЯ-ны захиалгаар хэрэгжүүлэх шинжлэх ухаан, технологийн төсөлд ШУТ-ийн сангаас 2012 онд 3 төсөлд 174.2 сая, 2014 онд 1 төсөлд 47.8 сая төгрөг, 2015 онд 1 төсөлд 115.2 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба 2016 оноос 2 төслийг хэрэгжүүлэхээр шийдвэрлэв.		
		7."Хүнсний аюулгүй байдал" үндэсний хөтөлбөрийн зорилт, арга хэмжээ нэг бүрийн үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын болон орон нутгийн төсөвт тусгах болон олон улсын зээл, тусламж, төсөлд харилцан уялдаатайгаар, давхардалгүйгээр хамруулах замаар нэмэгдүүлэх арга хэмжээ авах. /СБТГ/	Хөтөлбөрийн эхний үе шатанд улсын төсвөөс 932.85 сая төгрөг зарцуулсан бөгөөд хоёрдугаар үе шат буюу 2013-2015 онд 684.8 сая төгрөгийг ХХАА-н төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад тусган зарцуулсан. Хөтөлбөр боловсруулах ажлын хэсгээс хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд нийт 661.2 тэрбум төгрөгийг Засгийн газраас санхүүжүүлэх шаардлагатай гэсэн тооцоо хийсэн бөгөөд үүний 0,24 хувийг улсын төсвөөс хөтөлбөрийн санхүүжилтэд олгосон байна. Нэгдсэн Үндэстний байгууллагаас “Кодексийн үндэсний чадавхийг бэхжүүлэх нь” төслийг /2013-2015 онд/ амжилттай хэрэгжүүлсэн ба “Загас, загасан бүтээгдэхүүний нийлүүлэлтийг нэмэгдүүлэхэд цөөрмийн аж ахуйг Монголд хөгжүүлэх” /2014-2016/ болон, “Органик хөдөө аж ахуйг дэмжих” /2014-2016/ төслүүдийг хэрэгжүүлж байна. Мөн Дэлхийн зөн Олон улсын байгууллага, USAID (CHF), IFAD зэрэг олон улсын байгууллагуудтай хүнсний аюулгүй байдлыг сайжруулах чиглэлээр хамтран ажиллаж байна. Швейцарь улсын техник хамтын ажиллагааны нийгэмлэгээс хэрэгжүүлэх “Хүнсний ногоо” дэд хэсгийн суурь судалгаа гаргаж хэлэлцүүлэг зохион байгуулж төсөл 2016 оноос хэрэгжихээр болов. Мөн Солонгос улсын КОЙКА олон улсын байгууллагатай хамтран “Малын гаралтай бүтээгдэхүүний үл мөрийг мөшгин тогтоох” төслийг 2016 оны 01 дүгээр сараас 3 жилийн хугацаатай хэрэгжүүлэхээр ажиллаж байна. Орон нутаг, түүнчлэн уг хөтөлбөрийн хэрэгжилтэд оролцдог бусад салбарын хүрээнд хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэхээр улсын төсвөөс болон гадаадын зээл тусламж, төслийн шугамаар зарцуулсан хөрөнгийн талаар мэдээлэл хангалтгүй байна.		30
3	Том төрөөс ухаалаг төр рүү 2013-12-20 №: 52/32	4 Төрийн байгууллагуудад: Байгууллагадаа ухаалаг төрийн зарчмыг нэвтрүүлэх талаар хэлэлцүүлэг явуулж, 2014 оны үйл ажиллагааны төлөвлөгөөндөө тодорхой ажлыг хариуцах эзэн, тодорхой хугацаатайгаар тусган хэрэгжүүлж, дээд шатны болон аудитын байгууллага, олон нийтэд тайлагнах /ТЗУГ/	Төрийн зарим чиг үүргийг мэргэжлийн холбоод болон төрийн бус байгууллагаар гэрээгээр гүйцэтгүүлсэн ажлын хэрэгжилтэд хяналт тавьж, тайлан мэдээг хагас жилээр гарган ЗГХЭГ-т болон Хууль зүйн яаманд цаг тухайд нь хүргүүлж ажиллалаа. УИХ-д өргөн барих хуулийн , УИХ-ын тогтоолын , сайдын тушаалаар батлагдах захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төслүүдийг www.parliament.mn болон яамны цахим хуудсанд 30 хоног байршуулан нийтээр дагаж мөрдөх шийдвэрийн төсөл боловсруулах журмын дагуу хэлэлцүүлэг зохион байгуулж холбогдох төрийн ба төрийн бус байгууллага,мэргэжлийн шинжээч, эрдэмтэд, иргэдийн саналыг авч, тусган ажилласан.	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай .	90

4.	Олон улсын гэрээ байгуулах үйл ажиллагааг сайжруулах тухай 2014 46/26	1. Улс хоорондын болон Засгийн газар хоорондын гэрээ байгуулахдаа дараах журмыг чанд баримтлах: 1.1.Гэрээ байгуулахдаа үндэсний язгуур ашигсонирхолыгүндэс болгох; 1.2.Гэрээг Үндсэн хууль болон бусад хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Гадаад бодлогын үзэл баримтлалд нийцүүлэх; 1.3.Гадаад харилцааны сайд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дугаар хэсгийн 4-т заасны дагуу гэрээ байгуулах чиглэлээр үндсэн чиг үүргийг хэрэгжүүлж, гол хариуцлага хүлээх; 1.4.Тодорхой гэрээ байгуулах асуудлаар Гадаад харилцааны яамтай зөвшилцөн төсөл, орчуулгыг нь албан ёсоор хянуулж дүгнэлт гаргуулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж байх; 1.5.Төрийн албан ёсны хэлний тухай хуулийн 5.10, 5.11-д заасныг баримтлан гэрээний төслийг заавал монгол хэлээр үйлдэх. 2.Байгууллага хоорондын гэрээ байгуулахдаа Гадаад харилцааны яамны санал, дүгнэлтийг авч, байгуулсан гэрээг Гадаад харилцааны яаманд бүртгүүлэх. 3.Гэрээ байгуулахаар яриа хэлэлцээ хийхдээ "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай" Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 2013 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 01/01 дүгээр зөвлөмж болон Засгийн газрын 2013 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 169 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-ыг мөрдлөг болгох. /ГХАХ/	“Францын хүнсний тусламжийн сангийн хөрөнгийг ашиглах тухай” Монгол–Францын Засгийн газар хоорондын хэлэлцээр, Монгол Улсын Хүнс, хөдөө аж ахуйн яам, Бүгд Найрамдах Болгар Улсын Хөдөө аж ахуй, хүнсний яам хооронд “Хөдөө аж ахуйн техник туслалцааны хөтөлбөр” хэрэгжүүлэх тухай хэлэлцээрүүдийг байгуулахдаа "Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам"-ыг мөрдлөг болгон Гадаад харилцааны яамны санал, дүгнэлтийг авч, байгуулсан гэрээг Гадаад харилцааны яаманд бүртгүүлсэн болно.	Хасах саналтай байна.	100
ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ					
1.	Хүнсний аюулгүй байдлыг хангах, архидан согтуурахтай тэмцэх талаар авах зарим арга хэмжээний тухай 2008 №04	1. Хүнсний аюулгүй байдлыг хангах зорилгоор Хүнсний тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Химийн хорт болон аюултай бодисын тухай зэрэг хууль тогтоомж болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан дүрэм, журмын хэрэгжилтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд М.Энхболд, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Ц.Ганхуяг, Эрүүл мэндийн сайд Б.Батсэрээдэнэ, Байгаль орчны сайд Г.Шийлэгдамба, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай. /ХҮБХЗГ/	Хүнсний болон техникийн зориулалттай спиртийн хуваарилалт, олголт, зарцуулалт, түүнд хяналт тавих журам"-ыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд жил бүр спиртийн хуваарь батлуулан ажиллаж байна. Хүнс, хөдөө аж ахуйн сайдын 2004 оны 58 дугаар тушаалаар батлагдсан “Согтууруулах ундааны үйлдвэрийн төсөл сонгон шалгаруулах, үйлдвэрлэлд хяналт тавих журам”-ын хэрэгжилтэд Мэргэжлийн хяналт, татвар зэрэг холбогдох байгууллагууд хяналт тавин ажиллаж байгаа бөгөөд архины үйлдвэрийн тоо 2008 онд 92, 2012 онд 75 байсан бол 2016 оны эхний хагас жилийн байдлаар 48 болж 2008 оныхоос 52.2%, 2012 оныхоос 36%-аар тус тус буурсан. Тухайлбал, Говьсүмбэр, Хэнтий, Орхон, Сүхбаатар, Дорноговь зэрэг 5 аймаг архины үйлдвэргүй, Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан,	Хэрэгжилт тогтмолжсон тул хасах саналтай	100

			<p>Дундговь, Архангай, Сэлэнгэ, Булган, Баянхонгор, Өмнөговь зэрэг 10 аймаг тус бүр нэг үйлдвэр тусгай зөвшөөрөлтэй байна.</p> <p>Нийт үйлдвэрлэлийн бүтцэд өөрчлөлт орж, спиртийн өндөр агууламжтай үйлдвэрлэлийн хэмжээ буурч, 2015 оны жилийн эцсийн байдлаар шар айрагны үйлдвэрлэл хамгийн их буюу нийт согтууруулах ундааны үйлдвэрлэлийн 71.5%-ийг эзэлж байна</p> <p>ҮСХ-ны мэдээллээр согтууруулах ундааны үйлдвэрлэлийн хэмжээг өмнөх оны үзүүлэлттэй нь харьцуулахад 2013 онд спиртийн үйлдвэрлэл 41.7%, архи үйлдвэрлэл 2013 онд 7.6%, 2014 онд 2.4%, 2015 онд 12.6%-аар тус тус буурсан байна.</p> <p>ҮСХ-ны мэдээллээр нэг хүнд ногдох согтууруулах ундааны хэрэглээг архи, дарсанд шилжүүлж тооцоход 2008 онд 10.7 литр, 2012 онд 9.8 литр 2015 онд 7.2 литр болж буурчээ.</p> <p>“Хүнсний тухай” болон “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулиуд шинээр болон шинэчлэн батлагдсантай холбогдуулан ҮХААЯ-ны ТНБД-ын 2012 оны А/104 тоот тушаалаар эдгээр хуулиудад заасан дүрэм, журам, аргачлал, зөвлөмжийг боловсруулах төлөвлөгөөг, ажлын хэсгийн бүрэлдэхүүний хамт баталсан. Нийт 21 журмыг баталж, хэрэгжилтэд холбогдох байгууллагууд хяналт тавин хамтран ажиллаж байна.</p> <p>“Хүнсний тухай” хуулийн хэрэгжилтэнд үнэлгээ хийх ажлын хэсгийг байгуулан, үнэлгээ хийхээр ажиллаж байна.</p>		
2.	Төлөвлөгөө батлах тухай (Төрөөс малчдын талаар баримтлах бодлого) 2009 № 208	3. Төлөвлөгөөний хэрэгжилтийн явц, дүнг жил бүрийн I улиралд Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд үүрэг болгосугай. /МААБХЗГ/	Төрөөс малчдын талаар баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээллийг жил бүр ЗГХЭГ-т хүргүүлэн ажиллаж байна.		90
3.	Төлөвлөгөө батлах тухай (Монгол мал хөтөлбөрийн) 2010.05 № 222	3."Монгол мал" үндэсний хөтөлбөрийн биелэлт, үр дүнг нэгтгэн, жил бүрийн I улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунайд үүрэг болгосугай. /МААБХЗГ/	Тайлант 2015 онд хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн биелэлтийн ерөнхий дундаж үнэлгээ 67.8 хувьтай буюу “Хангалттай” гэж үнэлэгдэж байна. Үүнээс нэг дүгээр тэргүүлэх чиглэлийн биелэлт 74.0 хувьтай, хоёрдугаар тэргүүлэх чиглэлийн биелэлт 74.3 хувьтай, гуравдугаар тэргүүлэх чиглэл 57.8 хувьтай, дөрөвдүгээр тэргүүлэх чиглэл 60.5 хувьтай, тавдугаар тэргүүлэх чиглэл 72.6 хувийн биелэлттэй байна. Уг хөтөлбөр нь 2021 он хүртэл үргэлжлэх бөгөөд хэрэгжилт удаашралтай болон хэрэгжээгүй арга хэмжээг 2016-2021 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлэх бүрэн боломжтой гэж дүгнэж байна. Монгол Улсын Засгийн газрын 2010 оны 222 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол мал” үндэсний хөтөлбөрийн эхний үе шатанд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнөөс 11 арга хэмжээ удаашралтай хэрэгжиж, 11 арга хэмжээгүй байна.		100

			Үнэлгээний тайлангийн дүнг газрын даргад танилцуулан, Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хүргүүлж, яамны “АСУ” программын төлөвлөгөө тайлан мэдээллийн санд оруулав.		
4.	БНХАУ-ын хөнгөлөлттэй зээл 2014.08.01 № 41	ҮИ.1. БНХАУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд Булган аймгийн Хутаг-Өндөр суманд 15.0 мянган тоннын, Сэлэнгэ аймгийн Баянгол суманд 16.0 мянган тоннын, Увс аймгийн Баруунтуруун суманд 20.0 мянган тоннын, Хэнтий аймгийн Өмнөдэлгэр суманд 20.0 мянган тоннын, Дорнод аймагт 20.0 мянган тоннын элеватор тус тус барих "Үр тарианы элеватор байгуулах" төслийг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулахыг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндоржид даалгав. /ГТБХЗГ/	Элеватор байгуулах ТЭЗҮ-ийн баримт бичигт байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэж дуусгасан. БНХАУ-ын Экзим банкны төлөөлөгчидтэй хамтран нарийвчилсан үнэлгээний явцтай танилцаж, орон нутгийн удирдлагатай уулзан нийгэм, эдийн засгийн ач холбогдлыг үнэлэн санал солилцсон. Монгол Улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн 2015 оны намар БНХАУ-д хийсэн албан айлчлалын үеэр засгийн газар хоорондын гэрээгээр хэрэгжүүлэх ажлын жагсаалтад оруулж соёрхон батлахаар оруулсан боловч Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс элеватор байгуулах ажлыг өөрчлөхөөр шийдвэрлэсэн. Японы Засгийн газраас үзүүлсэн КР-2 хүнсний бус буцалтгүй тусламжийн хөтөлбөрийн хуримтлалын сангийн 4,6 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2012-2013 онд Төв аймгийн Угтаалцайдам суманд 36,0 мянган тонн багтаамжтай төмөр бетон элеваторыг сэргээн засварлаж ашиглалтад оруулсан, Улсын төсвийн 16,0 тэрбум төгрөгийн эх үүсвэрээр 2014-2015 онд Дархан-Уул аймагт 36,0 мянган тонн багтаамжтай төмөр бетон элеватор худалдан авч ашиглалтад оруулсан. Мөн хувийн өмчийн хөрөнгө оруулалтаар Алтай групп ХХК 2014 онд Дорнод аймгийн Халхгол суманд 10,0 мянган тоннын элеваторыг байгуулж ашиглалтад оруулсан, Энсада тракторон ХХК Хэнтий аймгийн Хурх тосгонд 10,0 мянган тонн багтаамжтай элеватор байгуулах ажлаа эхлүүлсэн байна.		70																		
	Бага оврын трактор 2014.08.14 №44	ХҮИ.П.а.2. Мөн хэлэлцээрийн хүрээнд 2012 онд худалдан авсан бага оврын тракторын борлуулалтын явц болон борлуулалтыг эрчимжүүлэх арга хэмжээний талаар Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайд Ш.Түвдэндорж, мөн зээлийн хөрөнгөөр худалдан авч ашиглахгүй байгаа зүтгүүрүүдийг ашиглах эсхүл худалдан борлуулах талаарх саналаа Зам, тээврийн сайд А.Гансүх Засгийн газрын хуралдаанд 14 хоногийн дотор танилцуулахыг тус тус даалгав. /ГТБХЗГ/	Аймгийн Хүнс, хөдөө аж ахуйн газруудтай гэрээ байгуулан бага оврын тракторуудыг орон нутагт хүргүүлж иргэдэд ойртуулан борлуулалтыг түргэтгэх ажлыг зохион байгуулснаар 2012-2015 онуудад нийт 7300 ширхэг бага оврын тракторыг малчид, тариаланчидтай гэрээ байгуулан зээлээр олгосон байна.Өнөөдрийн байдлаар 1100 тракторын үлдэгдэлтэй байна. <table border="1" data-bbox="913 1077 1751 1300"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>2012</th> <th>2013</th> <th>2014</th> <th>2015</th> <th>2016*</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Гадаадын зээл, сая доллар (Бага оврын трактор)</td> <td>10.1</td> <td>3.0</td> <td>2.6</td> <td>7.8</td> <td>-</td> </tr> <tr> <td>Бага оврын трактор</td> <td>3153</td> <td>908</td> <td>801</td> <td>2438</td> <td>1100</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016*	Гадаадын зээл, сая доллар (Бага оврын трактор)	10.1	3.0	2.6	7.8	-	Бага оврын трактор	3153	908	801	2438	1100		90
Үзүүлэлт	2012	2013	2014	2015	2016*																		
Гадаадын зээл, сая доллар (Бага оврын трактор)	10.1	3.0	2.6	7.8	-																		
Бага оврын трактор	3153	908	801	2438	1100																		
	"Биокомбинат" 2014.11.21 № 59	II.2. "Биокомбинат" ТӨААТҮГ-ыг шинэчлэхэд Унгар Улсын Засгийн	Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Унгар Улсын Засгийн газар хооронд Биокомбинат ТӨҮГ-ын иж бүрэн шинэчлэлийн төслийг санхүүжүүлэх		50																		

6.		газрын хөнгөлөлттэй зээл авах эсэх асуудлыг ойрын хугацаанд эцэслэн шийдвэрлүүлэхийг Үйлдвэр, хөдөө аж ахуйн сайдын үүрэг гүйцэтгэгч Ш.Түвдэндоржид даалгав. /СБТГ, МААБХЗГ, МЭҮГ/	зорилго бүхий “Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн хэлэлцээр”-ийг 2016 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр байгуулсан. Хэлэлцээрийн хүрээнд Биокомбинат ТӨҮГ-ын иж бүрэн шинэчлэлийг Унгарын Засгийн газрын 25 сая ам.долларын нэн хөнгөлөлттэй зээлээр санхүүжүүлэхээр болсон. Хоёр талаас Ажлын хэсгийг байгуулан төслийн техникийн даалгаврыг гаргахаар ажиллаж байна.		
7.	Төрийн гадаад бодлого 2014.12.15 № 63	IX.3.Монгол Улсын гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах талаар Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Засгийн газрын 2013 оны 169 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг хангах журам”, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2013 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” 01/01 дүгээр зөвлөмжийг Засгийн газрын гишүүдэд тарааж үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг даалгав. /ГХАХ/	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс 2013 оны 01 дүгээр сарын 08-ны өдөр баталсан “Төрийн гадаад бодлого, үйл ажиллагааны нэгдмэл байдлыг сайжруулах тухай” 01/01 дүгээр зөвлөмжийг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.		70
8.	2015.01.07 № 1	XII.4 Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолын хэрэгжилтийн талаар Хууль зүйн сайд Д.Дорлигжав Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүд, бүх шатны Засаг дарга, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав: 4.1. Засгийн газрын 2010 оны 119 дүгээр тогтоолоор баталсан “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдөж, захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн төсөл боловсруулахдаа эрх, ашиг сонирхол	4.1. Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахдаа “Захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргах журам”-ыг мөрдөж байна. Шийдвэрийн төсөлд яамны вэб сайтаар санал авч, мэргэжлийн байгууллага ороцуулсан хэлэлцүүлэг хийж, саналыг тусган ажиллаж байна. 4.2.Хүнс, хөдөө аж ахуйн салбарт мөрдөж буй захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрүүдэд хяналт-шинжилгээ хийж тайланг Хууль зүйн яаманд хүргүүлсэн.		70

		<p>нь хөндөгдөж байгаа этгээдийн саналыг авч, шаардлагатай бол саналыг тусгах арга хэмжээ авах; 4.2. захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрийн улсын нэгдсэн санд бүртгэлтэй эрх зүйн актын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ хийж, үр дүнг тооцож байх; 4.3. шинээр гарсан хууль тогтоомжид нийцүүлэн захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэрт тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулж байх; 4.4. хуулиар тусгайлан эрх олгоогүй асуудлаар захиргааны хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахгүй байх /ТЗУГ/</p>	<p>4.3.Шинээр батлагдсан хуульд заасны дагуу холбогдох шийдвэрийг батлан ажиллаж байна. Тухайлбал, Тариалангийн тухай хуулийн 21.4 дэх заалтыг үндэслэн Хүнсний буудайг хүлээн авах, хадгалалтын үеийн хэвийн хорогдлыг тооцох аргачлалыг Сайдын 2016 оны А-80 дугаар тушаалаар батлан улсын нэгдсэн бүртгэлийн 3643 дугаарт бүртгүүлэв. Хүнсний тухай хуулийн 6.7 дахь хэсгийг үндэслэн 2016 онд экспортлох болон импортлох стратегийн хүнсний нэр төрөл, тоо хэмжээг Сайдын 2015 оны А-124, А-139, 2016 оны А-40, А-81 дүгээр тушаалуудаар батлан улсын бүртгэлийн 3565, 3583, 3623 дугааруудад бүртгүүлэв. Мөн Улсын Их Хуралд өргөн барьсан Мал, амьтны эрүүл мэндийн тухай болон Малын генетик нөөцийн тухай хуулийн төслүүдэд тусгайлан эрх олгосон заалтуудыг тусган хууль батлагдмагц холбогдох журмуудыг батлахаар төслийг боловсруулж байна.</p>		
9.	Хүнсний улаан буудайн тариалалт 2015.01.26 № 05	<p>ХИҮ.2. Хүнсний улаан буудайн тариалалтыг дэмжих зорилгоор экспортод гаргах рапст ногдуулах гаалийн албан татварт улирлын чанартай зохицуулалт хийх асуудлыг судалж, санал боловсруулан Засгийн газарт оруулахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгав. /СБТГ/</p>	<p>Судалгаа хийгдэж байна.</p>		10
10.	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 2015.03.02 №13	<p>ХП.2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн явц, үр дүнгийн талаар Сангийн сайд Ж.Эрдэнэбат Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан: 2.1. Дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 2.1.1. шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулан тайланг улирал тутам гаргаж Сангийн яаманд хүргүүлж, холбогдох мэдээллийг цахим хуудсандаа тогтоосон хугацаанд байршуулж байх; 2.1.2. Шилэн дансны тухай хуулийн 8.2-т заасны дагуу харьяа байгууллагуудын шилэн дансны үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах.</p>	<p>Хүнс, хөдөө аж ахуйн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн хэрэгжилтийг тухай бүрт нь шилэн дансанд байршуулж байна.</p>		70

		/СБТГ/			
11.	Мянганы хөгжлийн зорилт 2015.04.06 №19	“Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгагдсан зорилт, арга хэмжээний хүрээнд удааширч байгаа зорилтуудын хэрэгжилтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгов. /ХШҮДАГ/	УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-ыг хүчингүй болгосон.	Хүчингүй болсон тул хасах саналтай байна.	90
12.	2015 оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын 2015 оны төлөвлөгөөг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай 2015.04.27 № 23	2.Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, хэрэгжилтийн явцад байнгын хяналт тавьж, гэрээнд заасан хугацаанд ажлыг дуусгах, гүйцэтгэлийг гаргуулан хянан баталгаажуулах, барилга байгууламжийг ашиглалтад хүлээн авах ажлыг шуурхай зохион байгуулах. /СБТГ/	Монгол Улсын 2015 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн дагуу төсөвт өртөг нь нэмэгдсэн УМЭАЦТЛ-ийн өргөтгөлийн барилгын үндсэн гүйцэтгэгчээр шалгарсан “Ди Си Эйч” ХХК-тай шууд гэрээ байгуулан үргэлжлүүлэн ажиллаж байна. Монгол-Японы хооронд байгуулсан Эдийн Засгийн түншлэлийн хэлэлцээрийн Дэд хорооны Монголын хэсгийг байгуулж Японы талд мэдэгдсэн болно. Монгол-Японы хооронд Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийн хүрээнд Хорио цээр, ургамал хорио цээрийн тусгайлсан бүлэг хэлэлцээг хийж дууссан бөгөөд дээрх хэлэлцээрийг Монгол Улсын хүнс, хөдөө аж ахуйн салбарын бизнес эрхлэгчдэд танилцуулах арга хэмжээг 2015 оны 4 дүгээр сард зохион байгуулсан.	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай.	70
13.	Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төсөл 2015.5.18 № 28	XXII. Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг хэлэлцэн дэмжээд үзэл баримтлалыг баталж, хуулийн төслийг орон нутгийн захиргааны байгууллага болон тариалан эрхлэгчдийн саналыг авч тусган боловсруулж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Тариалангийн тухай хуулийн төслийг 2015 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж Засгийн газрын гишүүдийн саналыг тусган 2016 оны 01 дүгээр сарын 28-нд батлуулав.	Хасах саналтай.	100
14.	Хөрс хамгаалал, мал аж ахуй, газар тариалангийн бүс нутгийн заагийг тогтоох, махны экспорт, малчны лавлах утас зэрэг арга хэмжээний талаар	III.Тариалангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх, хөдөө аж ахуйн салбарт хэрэгжиж байгаа гадаадын зээл, тусламжийг бордоо, ургамал хамгааллын бодис, техник, технологийн шинэчлэлд ашиглах, мал, мах, хөдөө аж ахуйн гаралтай бусад	III.Тариалангийн тухай хуулийн төслийг УИХ-аар хэлэлцэхээр шийдвэрлэн УИХ-аас ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Тус хуулийн төслийг УИХ-ын хэлэлцүүлэгт бэлтгэх ажлын хүрээнд Байгаль орчин хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо, Хүнс, хөдөө аж ахуйн яам хамтран 2015 оны 12 дугаар сарын 22-ны өдөр оролцогч талуудыг оролцуулсан хэлэлцүүлэг зохион байгууллаа. ОХУ-ын бүх нутаг дэвсгэрт адууны мах, адууны дайвар бүтээгдэхүүн, адууны өөх тос нийлүүлэх, тус улсын өмнөд мужууд дахь боловсруулах үйлдвэрүүдэд ястай үхрийн мах, үхэр, хонь, ямааны ясгүй мах болон үхрийн дайвар бүтээгдэхүүн, үхрийн өөх тосыг, нийлүүлэх боломжтой болсон.		90

	2015.06.04 №33	бүтээгдэхүүний экспортыг тухайн импортлогч улсуудын хорио цээрийн байгууллагуудтай харилцан тохиролцож шийдвэрлэх, малчны лавлах шуурхай утсыг ажиллуулах зэрэг арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав. /СБТГ/	БНХАУ Монгол Улсын баруун 5 аймагт тавьсан шүлхийн хоригийг цуцалсан бөгөөд тус улстай хамтран дулааны аргаар боловсруулсан мах, махан бүтээгдэхүүнийг экспортлох хүнсний аюулгүй байдлын хамтын ажиллагааны санамж бичиг, адууны махан бууз, банш экспортлох тухай санамж бичиг, адууны ясны гурил экспортлох үеийн мал эмнэлэг, хорио цээрийн тухай протоколд гарын үсэг зурсан. Харин хонь, ямаа, үхрийн мах экспортлохтой холбогдсон хяналт, хорио цээр, мал эмнэлэг, ариун цэврийн шаардлагын тухай протокол болон мал эмнэлэг, ариун цэврийн гэрчилгээний загварт гарын үсэг зурахаар бэлтгэл хангаж байна. Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас га-ийн ургацыг нэмэгдүүлэх, хөрсний үржил шимийг сайжруулах зорилгоор Япон Улсын хүнсний тусламжийн хөрөнгөөр “Нийлмэл бордоо” нийлүүлэх ТШ-КР1-2015/БН-01 дугаар бүхий бараа нийлүүлэх гүйцэтгэчийг сонгон шалгаруулах тендерийг зохион байгуулж байна. Энэхүү ажлыг зохион байгуулснаар газар тариалан эрхлэгч аж ахуйн нэгж, иргэд хөнгөлөлттэй нөхцөлөөр бордоо авах боломжтой болно.		
15.	2015.06.15 №36	ХХҮ.2.“Таримал ургамлын үр үржүүлгийн хөтөлбөр”-ийн санхүүжилтийг Оросын Холбооны Улсын хүмүүн-лэгийн тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх тухай саналыг хэлэлцээд, уг асуудлыг Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын хуралд оруулан хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Сангийн сайд Ж.Эрдэнэбат нарт даалгав /СБТГ, ГТБХЗГ, ХҮБХЗГ/	“Монголын цаг уурын нөхцөлд тохирсон, эрт болцтой, өвчин, ганд гэсвэртэй үр тарианы сорт гаргах, нутагшуулах хамтарсан хөтөлбөр”-ийг ОХУ-ын хүмүүнлэгийн тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх тухай саналыг Монгол-Оросын Засгийн газар хоорондын комиссын 19 дүгээр хурлаар оруулан хэлэлцүүлэхийг үүрэг болгосны дагуу хурлын Протоколд тус хөтөлбөрийг 2016 онд хэрэгжүүлж эхлэх талаар санал тусгасан болно. Хөтөлбөрийн Монголын талын төслийг боловсруулж Оросын талд хүргүүлсэн байна.		30
		ХХХҮ.7.БНХАУ-ын Засгийн газраас олгосон 500.0 сая ам.долларын хөнгөлөлттэй зээлийн хүрээнд хэрэгжүүлэх Аймгуудын хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний хангамжийг сайжруулах төсөл, Нүүрснээс синтетик байгалийн хий үйлдвэрлэх төслийн худалдан авах ажиллагааг шуурхай зохион байгуулж, холбогдох бусад төслүүдийн Тусгайлсан зээлийн хэлэлцээрийг ойрын үед байгуулахыг Сангийн сайд Ж.Эрдэнэбат, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Зам	ХХХҮ.7.БНХАУ-ын Засгийн газрын экспортын зээлийн хөрөнгөөр “Сүүний хөргөлтийн төвийн техник, тоног төхөөрөмж худалдан авах” хэлэлцээрийг БНХАУ-ын "China National Technical Import & Export Corporation" (CNTIC) компанитай хийж, “Сүүний хөргөлтийн төвийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, машин механизм худалдан авах гэрээ”-нд гарын үсэг зурсан. БНХАУ-ын ЭКЗИМ банкны удирдлагууд 2015 оны 2 дугаар сард “Сүүний хөргөлтийн төвийн техник, тоног төхөөрөмж нийлүүлэх” тендерийн CNTIC-МOIAOM2013 дугаартай гэрээг үргэлжлүүлэх эсэх талаар Сангийн яам, ХХААЯ-ны удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан ба манай талаас “Сүүний хөргөлтийн 50 төв байгуулах гэрээ”-г хэрэгжүүлэх саналыг тавьсан бөгөөд ЭКЗИМ банк уг саналыг судалж байна. Тусгайлсан зээлийн гэрээ байгуулагдсанаар төсөл хэрэгжиж эхэлнэ. Төсөл хэрэгжсэнээр хоногт 2-5 тонн сүү хүлээн авах хүчин чадалтай 50 хөргөлтийн төв нь жилд /90 хоног/ 10-20		70

		тээврийн сайд Н.Төмөрхүү, Уул уурхайн сайд Р.Жигжид, Нийслэлийн Засаг дарга Э.Баг-Үүл нарт тус тус даалгав. /СБТГ, МААБХЗГ, ГТБХЗГ, ХҮБХЗГ/	мянган тонн чанар, аюулгүй байдлын шаардлага хангасан сүүг боловсруулах үйлдвэрт нийлүүлж, Улаанбаатар хотын сүүний үйлдвэрүүдийн хүчин чадлын ашиглалтыг 20 хувиар нэмэгдүүлэх боломж бүрдүүлнэ.		
16.	Үндэсний хөтөлбөрүүдийн 2014 оны хэрэгжилтийн нэгдсэн дүн 2015.06.29 №39	XXXII.1. Эрхэлсэн асуудлын хүрэн дэх зорилго, зорилт нь давхардаж байгаа хөтөлбөрүүдийг нэгтгэж, 2015 онд хэрэгжиж дуусах хөтөлбөрийн биелэлтэд үнэлгээ өгч, хэрэгжилт нь удааширсан буюу тасарсан хөтөлбөрийг эрчимжүүлэх талаар тодорхой санал боловсруулан засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэрлүүлэхийг Засгийн газрын гишүүд, Засгийн газрын агентлагийн дарга нарт даалгав. /ХҮБХЗГ, ГТБХЗГ, МААБХЗГ/	<p>XXXII.1. Хөтөлбөрийн эхний үе шат /2009-2012 он/-нд хүрэхээр төлөвлөсөн 21 үр дүн, шалгуур үзүүлэлтийн хэрэгжилтийн дундаж үнэлгээ 78.0 хувьтай дүгнэгдсэн. Хөтөлбөрийн 2 дахь үе шат /2013-2016 он/-нд 4 тэргүүлэх чиглэлийн хүрээнд дараах 17 үр дүн гарахаар төлөвлөснөөс 2014 оны “Хүнсний аюулгүй байдал” үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээгээр 50.7 хувьтай үнэлэгдсэн байна. 2015 онд дараах ажлуудыг эрчимжүүлэн ажиллаж байна. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Хөтөлбөрийн зорилт, үр дүнгийн хүрээнд хэрэгжилтийн түвшин нь доогуур үнэлгээтэй заалтын биелэлтийг эрчимжүүлэх удирдлага, зохион байгуулалтын бодитой арга хэмжээ авах; - Хүнсний салбарын эрх зүйн орчин, орон нутаг дахь харъяа байгууллагын зохион байгуулалтын бүтэц шинэчлэгдсэнтэй холбогдуулан аймаг, нийслэлийн үйлдвэр, хөдөө аж ахуйн газрын хүнсний үйлдвэрийн асуудал хариуцсан мэргэжилтнүүдийг салбарын менежментийг сайжруулах, судалгаа, тооцооны шинэ арга зүй эзэмшүүлэх чиглэлээр нэгдсэн сургалтад хамруулах; - Хүнсний үйлдвэр, нийтийн хоолны газар, тэдгээрийн хүчин чадал, ашиглалт, зээл тусламжид хамрагдсан байдал, түүхий эдийн хангамж, хүний нөөц, борлуулалтын сүлжээ зэрэг хүнс үйлдвэрлэлийн бүх шатанд шаардлагатай мэдээллийн бааз бүрдүүлэх судалгааны хэрэгцээг тодорхойлж, эрэмбэлэн судалгаа явуулах; - Аймаг бүр өөрийн брэнд бүтээгдэхүүнийг бий болгон баталгаажуулахад анхаарч, хүнсний брэнд бүтээгдэхүүний найрлага, стандартыг баталгаажуулах, сав, баглаа боодол, шошгоны стандартыг мөрдөж, брэнд бүтээгдэхүүний технологийг улам боловсронгуй болгон нийтийн хэрэгцээнд нийлүүлэх болон экспортлох боломжийг бүрдүүлэх, бүтээгдэхүүний сурталчилгааг сайжруулах; - Хүнсний үйлдвэр цехийн үйл ажиллагаа, өрхийн тариалан эрхлэлтийг дэмжиж, хүн амын хүнсний хэрэглээнд чухал ач холбогдол бүхий органик гаралтай шинэ бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх зэрэг болно. 	Хугацаан ы хувьд ач холбогдол гүй тул хасах саналтай.	100
17.	2015 оны 07 дугаар сарын 20-ны өдөр 43 дугаар тэмдэглэл 2015-07-20 №:43	ХХҮ.1. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, удаашралтай болон тасарч байгаа заалтын биелэлтийг эрчимжүүлж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. /ХШҮДАГ/	Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж, удаашралтай болон тасарч байгаа заалтын мэдээллийг цаг тухай бүрт холбогдох газруудтай уулзалт зохион байгуулсан. Мөн товхимол бэлтгэн хүргүүлэв.		90
	Хүнсний	XI.2.Хүнс, хөдөө аж ахуйн сайд	Байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйл, гангийн улмаас 75.6 мянган га	Хугацааны	90

18	улаанбуудайг гурилын үйлдвэрт нийлүүлэх тухай 2015.08.24 №48	Р.Бурмаа 2015 оны ургацын урьдчилсан балансын дүнг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнэтэй холбогдуулан ургац хураалтын бэлтгэлийг сайтар хангуулж, хүнсний улаанбуудайг гурилын үйлдвэрт нийлүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу удирдан зохион байгуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав. /ГТБХЗГ/	талбай ургац алдаж, болц дутуу байснаас 32.8 мянган га талбай тэжээлд шилжсэнээр нийтдээ 108.4 мянган га талбайн ургац хураагдаагүй нь ургацын хэмжээг бууруулахад сөргөөр нөлөөлөв. Тиймээс асуудал боловсруулан Засгийн газарт танилцуулснаар энэхүү шийдвэрийг гаргуулж хэрэгжилтийг ТЭДС зохион байгуулахаар ажиллаж байна. ОБЕГ, ТЭДС хамтран тариаланчдын бэлтгэсэн ногоон тэжээлийг улсын нөөцөд өгөх ажлыг хэрэгжүүлэхээр ажилласан боловч нэгдүгээрт ногоон тэжээлийг улсын нөөцөд хүлээн авч хадгалах стандарт байхгүй, хоёрдугаарт нэг боодол ногоон тэжээлийг 5.0 мянган төгрөгөөр нийлүүлэх тариаланчдын саналыг Улсын нөөцийн газар хүлээн зөвшөөрөхгүй байгаагаас одоогийн байдлаар Улсын нөөцөд ногоон тэжээл нийлүүлэгдээгүй байна. 2016 оны тариалалтад зориулан тариалан бүхий аж ахуйн нэгж, иргэд 20.8 мянган тонн, ТЭДС 5.3 мянган тонн, ОБЕГ-ын УНГазар 1.9 мянган тонн, нийтдээ 28.0 мянган тонн үрийг дотоодын ургацаас бүрдүүлсэн бөгөөд дутагдах 126.0 мянган тонн хүнсний буудай, 20.0 мянган тонн үрийн буудайг импортоор авах ажлыг зохион байгуулж байна.	хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай байна.	
19	2015 оны 08 дугаар сарын 31-ны өдөр 49 дүгээр тэмдэглэл 2015-08-31 № 49	ХШ.3. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд үүрэг болгов: 1.1. биелэлт удаашралтай байгаа 31 арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлэх; 1.2. зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой заах /ХШҮДАГ/	Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2015 оны эхний хагас жилийн байдлаар 43.5 хувьтай үнэлэгдэв. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 1 арга хэмжээ, 3 нь 70 %, 4 нь 50%, 7 нь 30%, 2 нь 10 хувийн хэрэгжилттэй, тасарсан арга хэмжээ байхгүй байна. 2015 оны үндсэн чиглэлд 75.99 тэрбум төгрөг төлөвлөснөөс 11.41 тэрбум төгрөг зарцуулсан. Энэ нь төлөвлөсөн дүнгийн дөнгөж 15 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, холбогдох хавсралтуудын хамт Засгийн газрын үнэлгээний www.unelgee.gov.mn систем, яамны удирдлагын менежментийн систем АСУ, яамны цахим хуудас " mofa.gov.mn "-д байршуулав. Тайланг ТНБД-ын зөвлөлийн хуралд танилцуулан холбогдох шийдвэрийн дагуу ЗГХЭГ-т хүргүүлэв.	Хасах саналтай.	100
20.	Улсын Их Хурлын 2011 оны 30 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай 2015.10.05 № 54	ХШ. “Үндэсний үйлдвэр-лэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” УИХ-ын тогтоолын төсөл. Уг тогтоол батлагдсанаар гарах нэмэлт зардал, төсөв дээр ирэх ачааллыг тооцож, Сангийн яамтай тохирсны үндсэн дээр Засгийн газрын хуралдаанд оруулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав. /СБТГ/	“Үндэсний үйлдвэрлэгчдийг дэмжих, ажлын байр нэмэгдүүлэх зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2011 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн 30 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Улсын Их Хурлын тогтоол багтагдсанаар гарах нэмэлт зардал, төсөв дээр ирэх ачааллыг тооцож, Сангийн яамтай тохирсны үндсэн дээр тогтоолын төслийг Засгийн газрын 2015 оны 11 дүгээр сарын хуралдаанаар дахин хэлэлцүүлж дэмжигдэн УИХ-д өргөн мэдүүлсэн. УИХ-ын 2016 оны 05 дугаар сарын 16-ны өдрийн 44 дүгээр тогтоолоор тус тогтоолд өөрчлөлт орон батлагдсан.	Хасах саналтай.	100
	2015.10.12 №55	ХҮИ.Хөдөө аж ахуйн “Халх гол” чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий	Хөдөө аж ахуйн Халх гол чөлөөт бүсэд дагаж мөрдөх “Халх гол чөлөөт бүсэд тариалангийн үйлдвэрлэл эрхлэх журам”-ын төслийг боловсруулан олон		10

21		<p>төлөвлөгөөг дараах зарчмыг баримтлан боловсруулах арга хэмжээ авч, зохих журмын дагуу Засгийн газрын хуралдаанд оруулахыг Аж үйлдвэрийн сайд Д.Эрдэнэбат, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгав: 1.1. “Халх гол” чөлөөт бүсийн ерөнхий төлөвлөгөө нь Монгол Улсын хууль тогтоомжид нийцсэн байх; 1.2. “Халх гол” чөлөөт бүс нь олон улсын худалдааны хорио цээртэй мал, амьтны халдварт өвчнөөс ангид, эрүүл бүс байх; 1.3. “Халх гол” чөлөөт бүсэд тэг технологийг ашиглан тухайн бүс нутагт туршиж, баталгаажсан сортын үрээр тариалалт хийх; 1.4. “Халх гол” чөлөөт бүсэд үйлдвэрлэж гаалийн нутаг дэвсгэрт оруулах бүтээгдэхүүн байгальд ээлтэй технологиор үйлдвэрлэсэн, нэмүү өртөг шингэсэн, генийн өөрчлөлтгүй байх; 1.5. “Халх гол” чөлөөт бүсэд мал аж ахуйн болон газар тариалангийн үйлдвэрлэл, хөдөө аж ахуйн аялал, жуулчлал эрхлэх хуулийн этгээд нь 51-ээс дээш хувийн монголын талын оролцоотой байх; 1.6. “Халх гол” чөлөөт бүсэд ажиллах гадаадын иргэн, харьяалалгүй хүний тоо “Халх гол” чөлөөт бүсэд ажиллах Монгол Улсын иргэдийн 3 %-иас илүүгүй байх /СБТГ, ГТБХЗГ/</p>	<p>нийтээр хэлэлцүүлж байна. Хүнс, хөдөө аж ахуйн яамны цахим хуудасны баруун дээд буланд байгаа “Хэлэлцүүлэг” хэсэгт журмын төслийг байршуулан, санал авч байна.</p>		
22	<p>Ургац хураалтын талаар 2015.11.02 № 60</p>	<p>XXXI.5.Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа 2015 оны ургац хураалтын урьдчилсан байдал болон байгаль цаг агаарын давагдашгүй хүчин зүйлийн нөлөөгөөр ургац алдсан талбайгаас хураан авсан ногоон тэжээл, улсын нөөцөд төлөх шатахууны өр, түүнийг төлөх боломжийн талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан Онцгой байдлын ерөнхий газрын улсын нөөцөөс Тариалан эрхлэлтийг дэмжих санд</p>	<p>Байгаль цаг уурын давагдашгүй хүчин зүйл, гангийн улмаас 75.6 мянган га талбайн ургац алдаж, болц дугуу байснаас 32.8 мянган га талбай тэжээлд шилжсэнээр нийтдээ 108.4 мянган га талбайн ургац хураагдаагүй нь ургацын хэмжээг бууруулахад сөргөөр нөлөөлөв. Тиймээс асуудал боловсруулан Засгийн газарт танилцуулснаар энэхүү шийдвэрийг гаргуулж хэрэгжилтийг Тариалан эрхлэлтийг дэмжих сан зохион байгуулахаар ажиллаж байна. ОБЕГ, ТЭДС хамтран тариаланчдын бэлтгэсэн ногоон тэжээлийг улсын нөөцөд өгөх ажлыг хэрэгжүүлэхээр ажилласан боловч нэгдүгээрт ногоон тэжээлийг улсын нөөцөд хүлээн авч хадгалах стандарт байхгүй, хоёрдугаарт нэг боодол ногоон тэжээлийг 5.0 мянган төгрөгөөр нийлүүлэх тариаланчдын саналыг Улсын нөөцийн газар хүлээн зөвшөөрөхгүй байгаагаас одоогийн байдлаар Улсын нөөцөд ногоон тэжээл нийлүүлэгдээгүй байна.</p>	<p>Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай байна.</p>	<p>70</p>

		зээлээр авсан шатахууны үнэ болох 2.5 (хоёр тэрбум таван зуун сая) тэрбум төгрөгийн өрөнд 500 мянган боодол ногоон тэжээл нийлүүлэх асуудлыг судалж, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн шийдвэрлэхийг Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгав. /СБТГ, ГТБХЗГ, МААБХЗГ/			
23	2015 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр 68 дугаар тэмдэглэл 2015-11-30 №: 68	XIX.6. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа 2015 оны ургац хураалтын дүнг Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2016 оны тариалалтын бэлтгэлийг эртнээс хангаж, дутагдах хүнсний болон үрийн буудайг импортоор нийлүүлэх, гурилын хангамжийг тогтворжуулах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэхийг Сангийн сайд Б.Болор нарт тус тус даалгав.	2016 оны тариалалтад зориулан тариалан бүхий аж ахуйн нэгж, иргэд 20.8 мянган тонн, ТЭДС 5.3 мянган тонн, ОБЕГ-ын УНГазар 1.9 мянган тонн, нийтдээ 28.0 мянган тонн үрийг дотоодын ургацаас бүрдүүлсэн бөгөөд дутагдах 126.0 мянган тонн хүнсний буудай, 20.0 мянган тонн үрийн буудайг импортоор авах ажлыг зохион байгуулж байна.	Хугацааны хувьд ач холбогдолгүй тул хасах саналтай байна.	90
24	2016 оны 02 дугаар сарын 04-ний өдөр 08 дугаар тэмдэглэл 2016-02-04 №:8	Ү. 2. "Улсын сайн малчин", "Улсын тэргүүний фермер", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", Улсын тэргүүний тариаланч"-ийн шагналыг орон нутагт нь гардуулах Засгийн газрын гишүүд, бүрэлдэхүүнд нь орох төлөөллийг холбогдох албан тушаалтан болон орон нутгийн удирдлагатай зөвшилцөн хуваарь батлахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад, уг үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр олон нийтэд сурталчлах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа нарт даалгав.	"Улсын сайн малчин", "Улсын тэргүүний фермер", "Улсын тэргүүний тариаланч хамт олон", Улсын тэргүүний тариаланч"-ийн шагналыг орон нутагт нь гардуулах Засгийн газрын гишүүд, бүрэлдэхүүнд нь орох төлөөллийг холбогдох албан тушаалтан болон орон нутгийн удирдлагатай зөвшилцөн хуваарийг батлуулан, орон нутагт хүргүүлэх ажлыг зохион байгуулав. Шагналыг гардуулах үеэр тухайн малчны мал маллагааны онцлог, арга туршлагыг олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах арга хэмжээг зохион байгуулав.	Хасах саналтай.	100
	2016 оны 02 дугаар сарын 08-ны өдөр 09	ҮП. 2. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, түүнийг устгах талаар төрөөс	ХХАА-н сайдын 2016 оны А/33 дугаар тушаалаар салбарын мэргэжлийн байгууллагуудын төлөөллийг оролцуулан 14 гишүүнтэй ажлын хэсэг байгуулж,	Хасах саналтай	90

25	дүгээр тэмдэглэл 2016-02-08 №:9	баримтлах бодлогын баримт бичгийн төслийг боловсруулан, малын халдварт өвчнийг мэдээлэх, малын эмч нарыг чадавхижуулах арга хэмжээний талаарх саналын хамт 2016 оны I улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд оруулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх зааварт өөрчлөлт оруулах, уг өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратегийг шинээр боловсруулах ажлыг тус тус хийж гүйцэтгээд байна. Мал, амьтны гоц халдварт хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратегийн баримт бичгийг 2020 он хүртэл 5 жилийн хугацаанд мөрдөх бөгөөд тэмцэх сэргийлэх арга хэмжээг бүсчлэн хэрэгжүүлж, гадаад, дотоод худалдааны чөлөөт байдлыг хангах зорилго тавин ажиллана. ХХАА-н сайдын зөвлөлийн 2016 оны 06-р сарын 03-ны өдрийн хуралд танилцуулан холбогдох зарим өөрчлөлтийг тусган батлах саналаар дэмжигдээд байна. /МЭҮГ/	байна.	
26	2016 оны 02 дугаар сарын 15-ны өдөр 10 дугаар тэмдэглэл 2016-02-15- №:10	ХҮ.3. Мал эмнэлэг, үржлийн газрын даргыг сонгон шалгаруулж томилох хүртэл хугацаанд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчийг томилж, М.Галбадрахыг мэргэжил, мэргэшлийн дагуу өөр ажил, албан тушаалд ажиллуулах талаар холбогдох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Мал эмнэлэг, үржлийн газрын даргыг сонгон шалгаруулж томилох хүртэл хугацаанд даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр Д.Батцэнгэлийг ХХАА-н сайдын 2016 оны 02 дугаар сарын 29-ний өдрийн тушаалаар томилон ажиллууулж байна. /МЭҮГ/	Хасах саналтай байна.	100
27	2016 оны 02 дугаар сарын 22-ны өдөр 11 дүгээр тэмдэглэл 2016-02-22 №:11	ХIҮ. “Монгол орны хөрс, цаг уурын нөхцөлд тохирсон эрт болцтой, өвчин, ганд тэсвэртэй, арвин ургацтай үр тарианы сорт гаргах, нутагшсан сортын үр үйлдвэрлэл” хөтөлбөрийг Оросын Холбооны Улсын буцалтгүй тусламжаар хэрэгжүүлэх тухай Хүнс, хөдөө аж ахуйн яамны саналыг хэлэлцэн дэмжээд, уг саналыг холбогдох баримт бичгийн хамт оросын талд албан ёсоор хүргүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа, Гадаад хэргийн сайд Л.Пүрэвсүрэн нарт даалгав.	“Монгол орны цаг уурын нөхцөлд тохирсон эрт болцтой ган, өвчинд тэсвэртэй үр тариа, тэжээлийн таримлын шинэ сорт гаргах, нутагшсан сортын үр үржүүлэх” төслийг боловсруулан ОХУ-ын Засгийн газрын санхүүжилтээр хэрэгжүүлэхээр саналыг боловсруулан Сангийн ямаар хянуулж ЗГХЭГ-т хүргүүлэн Ерөнхий сайдын ОХУ-д хийсэн ажлын айлчлалаар хэлэлцэх асуудалд оруулсан болно. Түүнчлэн 2015 оны 11 дүгээр сарын 23-24 нд ОХУ-ын Чита хотод болсон хоёр Улсын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанаар дахин хэлэлцүүлж протоколд тусгуулав.		90
28	2016 оны 02 дугаар сарын 29-ний өдөр 12 дугаар тэмдэглэл 2016-02-29 №:12	ХХIII.1. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа Засгийн газрын 2010 оны 97 дугаар тогтоолоор баталсан “Халх гол төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явцын талаар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан “Халх гол төслийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө”-нд тусгасан Халх голын	Халх голын бүс нутагт 200 га талбайд мал аж ахуй газар тариалан хосолсон загвар аж ахуй байгуулах ажлын дуусаагүй шалтгаан болох гүйцэтгэгч байгууллагын нэмэгдэл ажлын санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэсэн. ХХААЯ, КОЙКА олон улсын хамтын ажиллагааны байгууллага, гүйцэтгэгч Вэлмот ХХК-иудын хооронд загвар аж ахуйг ажлыг эрчимжүүлэх, дутуу ажлуудыг гүйцэтгэх, үлдэгдэл санхүүжилтийг олгох талаар 3 тал 2016 оны 05 дугаар сарын 19 өдөр тохиролцсон. Дорнод аймгийн Тамгын газар, Хүнс, хөдөө аж ахуйн яамны мэргэжилтнүүд, Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газрын холбогдох хүмүүсийг оролцуулан 6 дугаар сарын сүүлээр Улсын комиссыг ажиллуулахаар төлөвлөж		ХБ

	<p>бүс нутагт 200 га талбайд мал аж ахуй, газар тариалан хосолсон загвар аж ахуй барьж байгуулах ажлыг дуусган 2016 оны 11 дүгээр сард багтаан хүлээн авах ажлыг зохион байгуулж, дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.</p>	байна.		
	<p>ХХИИ.2. Улсын төсвийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний жагсаалт баталсан Засгийн газрын 2015 оны 336, Засгийн газрын 2015 оны 455 дугаар тогтоолуудын хэрэгжилтийн явцын талаар Монгол Улсын Шадар сайд Ц.Оюунбаатар Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан 2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг энэ оны 3 дугаар сарын 7-ны дотор багтаан Худалдан авах ажиллагааны газарт баталгаажуулан хүргүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав.</p>	<p>2016 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний ажлын зураг төсөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, холбогдох бусад материалыг энэ оны 3 дугаар сарын 7-ны дотор багтаан Худалдан авах ажиллагааны газарт баталгаажуулан хүргүүлж ажилласан.</p>	Хасах саналтай.	100
	<p>ХХИИ.3. Хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн 2015 оны жилийн эцсийн дүнг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга С.Баярцогт Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав. 1. Улсын Их Хурлын болон Байнгын хорооны тогтоол, Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн шийдвэр, Засгийн газрын шийдвэрээр Засгийн газар, сайд,</p>	<p>Хүнс, хөдөө аж ахуйн салбарын 2015 оны худалдан авах ажиллагаанд удаашралтай арга хэмжээ байхгүй бөгөөд тайланг Сангийн яаманд 2016 оны 1 дүгээр сарын 14-ний өдрийн 1/106 албан тоотоор хүргүүлсэн.</p>	Хасах саналтай.	100

		Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасан заалт бүрийг хяналтад авч хэрэгжүүлэх ажлыг төлөвлөгөөний дагуу, шуурхай зохион байгуулах; 2. Үүрэг болгосон шийдвэрийн биелэлтийг тогтоосон хугацаанд “Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем” (www.unelgee.gov.mn)-д байршуулж, гарсан үр дүн, үр нөлөөг холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн бодитойгоор хяналт-шинжилгээ хийж үнэлэн тайлагнах; 3. 2015 оны жилийн эцсийн байдлаар тасарсан болон хэрэгжилт нь удааширч байгаа үүрэг, даалгаврыг биелүүлэх талаар онцгой анхаарч, хэрэгжсэн ажлыг Засгийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн систем (www.unelgee.gov.mn)-д бүртгүүлж, хяналтаас хасуулах; 4. Хуульд заасан эрх зүйн акт (дүрэм, журам, заавар, бусад)-ыг хугацаанд нь баталж мөрдүүлэх. /ХШҮДАГ/			
29	2016 оны 03 дугаар сарын 7-ны өдөр 14 дугаар тэмдэглэл 2016-03-07 №: 14	ХҮ. 2016 оны тариалалтад дутагдах үрийн улаанбуудайн нөөц бүрдүүлэхэд шаардагдах санхүүжилтийг Тариалан эрхлэлтийг дэмжих сангийн дотоод эх үүсвэрээс эргэн төвлөрүүлэх нөхцөлтэйгээр зохицуулалт хийж шийдвэрлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Шинэчилсэн тооцоогоор 2016 оны тариалалтад нийтдээ 48.0 мянган тонн үр шаардагдах бөгөөд дотооддоо 35.5 мянган тонн үрийн нөөц бүрдүүлж 12.5 мянган тонн үр дутагдах тооцоо гарсан. Дутагдах буудайн үрийн нөөц бүрдүүлэх зорилгоор ТЭДС сонгон шалгаруулалт зарлаж шаардлага хангасан 2 аж ахуйн нэгжтэй дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулан 5.6 мянган тонн импортын үрийн буудайн нөөц бүрдүүлсэн болно.	Хугацаан ы хувьд ач холбогдол гүй тул хасах саналтай.	90
30	2016 оны 03 дугаар сарын 21-ний өдөр 17 дугаар тэмдэглэл 2016-03-21 № 17	ҮҮ. 2. 2016 оны 4 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд Бүгд Найрамдах Болгар Улсын Софи хотод зохион байгуулах Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Болгарын Засгийн газар хоорондын комиссын 6 дугаар хуралдаанд оролцох монголын	Бүгд Найраамдах Болгар Улсын Софи хотноо 04 дүгээр сарын 02-ноос 06-ны өдрүүдэд зохион байгуулагдсан Монгол-Болгарын Засгийн газар хоорондын комиссын хуралдаанд оролцох Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа баталж энэхүү хуралдааны Монголын талыг даргалан оролцов.	Хасах саналтай.	100

		талын төлөөлөгчдийн баримтлах удирдамжийг хэлэлцэн зөвшөөрөв. 2. Уг хуралдаанд оролцох монголын талын төлөөлөгчдийн бүрэлдэхүүнийг батлахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд бөгөөд тус комиссын Монголын хэсгийн дарга Р.Бурмаад даалгав.			
31	2016 оны 03 дугаар сарын 28-ны өдөр 18 дугаар тэмдэглэл 2016-03-28 №: 18	XIX.3. “Монгол Улсын Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого”-д тусгасан зорилт, арга хэмжээг 2015 онд хэрэгжүүлсэн явцын тухай “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д тусгасан зорилт, арга хэмжээг цаашид хэрэгжүүлж ажиллахыг сайд, Засгийн газрын агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгав.	Тайлагнах хугацаа болоогүй.		ХБ
		XIX.4.2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлттэй холбогдуулан дараах арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав: 2.1. зорилт, арга хэмжээний биелэлтийг тайлагнахдаа зарцуулсан хөрөнгийн хэмжээг тодорхой заах; 2.2. үндсэн чиглэлд заасан зорилт, арга хэмжээний биелэлтийг шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэй нь уялдуулан тайлагнах.	Монгол улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуйн салбарт хамаарах арга хэмжээний ерөнхий гүйцэтгэл 2015 оны эхний хагас жилийн байдлаар 43.5 хувьтай үнэлэгдэв. Төлөвлөгдсөн арга хэмжээнээс бүрэн хэрэгжсэн 1 арга хэмжээ, 3 нь 70 %, 4 нь 50%, 7 нь 30%, 2 нь 10 хувийн хэрэгжилттэй, тасарсан арга хэмжээ байхгүй байна. 2015 оны үндсэн чиглэлд 75.99 тэрбум төгрөг төлөвлөснөөс 11.41 тэрбум төгрөг зарцуулсан. Энэ нь төлөвлөсөн дүнгийн дөнгөж 15 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь хангалтгүй үзүүлэлт юм. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2015 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн төлөвлөгөөг батлуулахдаа салбаруудыг бүрэн хамарч чадаагүй байна. Салбар бүрээс бүрэн орхигдсон асуудлуудыг харуулбал: <ul style="list-style-type: none"> • <u>Хүнсний салбарын</u> хувьд гурилын үйлдвэрлэл, органик хүнсний үйлдвэрлэл, хоол үйлдвэрлэл, үйлчилгээ, хүнсний аюулгүй байдалтай холбоотой ажлууд; • <u>Газар тариалангийн</u> салбарт үр сорт, хөрсний үржил шим, хамгаалагдсан хөрс, усалгаатай тариалан, жимс жимсгэнийн үйлдвэрлэл; • <u>Мал аж ахуйн салбарт</u> мал эмнэлэг, малын тэжээл, бэлчээр, бэлчээрийн усжуулалт, хөдөө аж ахуйн биржийн асуудал бүрэн 	Хасах саналтай	100

			<p>орхигдсон байна.</p> <p>Хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлан, холбогдох хавсралтуудын хамт яамны удирдлагын менежментийн систем АСУ, яамны цахим хуудас “mofa.gov.mn”-д байршуулав.</p>		
		<p>XIX.5.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрөөс хэрэгжилт нь удааширч байгаа зорилтуудыг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Засгийн газрын гишүүдэд даалгав.</p>	<p>Өгсөн чиглэлийн дагуу удаашралтай арга хэмжээг эрчимжүүлэх талаар холбогдох газруудад дотоод албан бичиг хүргүүлж, санал солилцов. Арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, мэдээ, мэдээллийг бүрэн авч ажилласнаар эдгээр 8 арга хэмжээнээс 2016 оны эхний хагас жилийн байдлаар 5 нь бүрэн хэрэгжиж, 50 хувиас доош үнэлгээтэй 3 арга хэмжээ байна.</p>	Хасах саналтай байна.	90
32	<p>2016 оны 04 дүгээр сарын 4-ний өдөр 20 дугаар тэмдэглэл 2016-04-04 № 20</p>	<p>XXIII.2. Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 оны худалдан авах ажиллагааны тайлан, хэрэгжилтэд хийсэн үнэлгээний дүнг Сангийн сайд Б.Болор Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээ авахыг төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгав: 1. Илэрсэн зөрчил, дутагдлыг арилгаж, цаашид худалдан авах ажиллагааг холбогдох хууль, журам, зааврын дагуу хэрэгжүүлэх, 2015 оны үнэлгээгээр хангалтгүй дүн авсан албан тушаалтанд хариуцлага тооцож, дүнг 2016 оны 4 дүгээр сард багтаан Сангийн яаманд танилцуулах; 2. “Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж, худалдан авах ажиллагааны улирлын тайланг нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж байх; 3. Монгол Улсын төсвийн тухай хуулиар баталсан урсгал төсвийн болон хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хүрээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тендерийг 2016 оны 5 дугаар сарын 1-ний өдрийн дотор</p>	<p>1.“Худалдан авах ажиллагааны 2015 оны хэрэгжилтэд үнэлгээ өгсөн ” Сангийн сайдын 2016.03.31-ний өдрийн 5/1859 тоотой ирүүлсэн албан бичгийн мэдээлэл нь зөрүүтэй байгаагаас Хүнс, хөдөө аж ахуйн сайдын багцын 2015 оны худалдан авах ажиллагааны хэрэгжилтэд үнэлгээг дахин нягтлан үзэх тухай 2016. оны 01/1295 тоот албан бичгийг Сангийн яаманд хүргүүлсэн.</p> <p>“Дотоодын үйлдвэрлэгчдийг дэмжих зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2014 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн 18 дугаар тогтоолын хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа бөгөөд худалдан авах ажиллагааны улирлын тайланг нэгтгэн цаг хугацаанд нь хүргүүлж байна. Хүнс,хөдөө аж ахуйн салбарын 2016 оны худалдан авах бараа, ажил, үйлчилгээний 1 дүгээр улирлын явцын тайланг 2016 оны 4 дүгээр сарын 7-ны өдрийн 01/1086 тоот албан бичгээр хүргүүлсэн.</p> <p>2.ХХАА-н салбарын 2016 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг сайдын 2015 оны А-165 дугаар тушаалаар батлуулсан бөгөөд 1 дүгээр улирлын байдлаар нийт 31 худалдан авах ажиллагаанаас 20 тендерийг зарлаж 11 гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан байна.</p> <p>3.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн бичиг баримтанд аж ахуйн нэгжүүд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах тухай тусган ажиллаж байна.</p> <p>4.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил,үйлчилгээ үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу тендерийн бичиг баримтанд аж ахуйн нэгжүүд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах тухай тусган ажиллаж байна.</p>		70

		зарлан, мөн оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор тендер шалгаруулалтыг зохион байгуулж дуусган, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж, ажлыг эхлүүлсэн байх; 4. Тендер шалгаруулалтын урилгыг олон нийтэд зарлан мэдээлэхдээ оролцогч аж ахуйн нэгжүүд Засгийн газрын бондоор тендерийн баталгаа гаргах боломжийг бүрдүүлэн ажиллах. /СБТГ/			
33	2016 оны 05 дугаар сарын 2-ны өдөр 25 дугаар тэмдэглэл 2016-05-02 №: 25	Бүгд Найрамдах Болгар Улсын Софи хотод 2016 оны 4 дүгээр сарын 4-5-ны өдрүүдэд зохион байгуулсан Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол, Болгарын Засгийн газар хоорондын комиссын 6 дугаар хуралдааны дүнг сайшааж, уг хуралдааны мөрөөр хэрэг-жүүлэх ажлын төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд, тус комиссын Монголын хэсгийн дарга Р.Бурмаад даалгав.	Худалдаа, эдийн засаг, шинжлэх ухаан, техникийн хамтын ажиллагааны Монгол-Болгарын Засгийн газар хоорондын комиссын 6 дугаар хуралдааны протоколыг хэрэгжүүлэх төлөвлөгөөг Хүнс, Хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа 2016 оны 05 дугаар сарын 03 –ны өдөр 27 заалттайгаар батлав.		70
		XVI. Хүнс, хөдөө аж ахуйн яам, Мал эмнэлэг, үржлийн газраас мэргэжлийн байгуул-лагатай хамтран боловсруулсан “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх заавар”-ын төслүүдийг хэлэлцээд холбогдох хууль тогтоомжийн дагуу батлан мөрдүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Хүнс, хөдөө аж ахуйн сайдын тушаалаар байгуулагдсан ажлын хэсгийн боловсруулсан “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх дунд хугацааны стратеги, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө”, “Хонь, ямааны цэцэг өвчинтэй тэмцэх заавар”-ын төслүүдийг ХХАА-н сайдын зөвлөлийн 2016 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн хурлаар авч хэлэлцээд зөвлөлийн гишүүдийн гаргасан саналыг тусган батлахыг дэмжсэн.		90
		XVII.2. Мал эмнэлгийн хяналтын цэгт хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмыг Засгийн газраас батлах эрх зүйн үндэслэл байхгүй тул Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 4.3.4-д заасныг дагуу батлан	Мал эмнэлгийн хяналтын цэгт хэрэгжүүлэх үйл ажиллагааны журмын төслийг боловсруулсан.		10

		мөрдүүлж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.			
		XXIII.5 Унгар Улсад ажлын айлчлал хийсэн тухай Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа Засгийн газрын гишүүдэд танилцуулав. Үүнтэй холбог-дуулан айлчлалын мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө гарган ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	Хүнс, Хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаа Унгар Улсын Будапешт хотноо 2016 оны 03 дугаар сарын 28-наас 04 дүгээр сарын 02-ны өдөр ажлын айлчлал хийж Унгарын хөдөө аж ахуйн сайдтай хоёр талын уулзалт хийв. 2015 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр Улаанбаатар хотноо гарын үсэг зурсан Санхүүгийн хамтын ажиллагааны ерөнхий хөтөлбөрийн тухай Монгол Улсын Засгийн газар Унгар Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг урагшлуулах талаар санал солилцож үүнтэй холбогдуулан 2016 оны 05 дугаар сарын 03-ны өдөр Сонгино дахь Биокомбинат ТӨҮГ-ын шинэчлэл төслийг Унгарын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэхтэй холбогдуулан ТЭЗҮ-ийн ажлын даалгаврын талаар санал зөвлөмж боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулав.		10
34	2016 оны 05 дугаар сарын 16-ны өдөр 28 дугаар тэмдэглэл 2016-05-16 №: 28	XXIV.4.1 Хаврын тариалалтад шаардлагатай импортоор оруулсан болон улсын нөөцөөс гаргаж байгаа үрийн улаанбуудайг тариаланчдад яаралтай олгож, үр тариа, төмс, хүнсний ногоо, тэжээлийн ургамал тариалах ажлыг технологийн хугацаанд зохион байгуулж, 2016 оны төлөвлөсөн зорилтоо ханган биелүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Р.Бурмаад даалгав.	2016 оны хаврын тариалалтад дутагдах 12.5 мянган тонн будайн үрийн 5.6 мянган тонныг нь импортоор, үлдэх 6.5 мянган тонныг нь дотоодын эх үүсвэрээс шийдвэрлэснээр нийтдээ 12.1 мянган тонн үрийн буудайг 30 хувийн урьдчилгаатайгаар 345 аж ахуйн нэгж, иргэнд зээлээр олгож технологийн хугацаанд нь төлөвлөсөн хэмжээндээ тариалалт явуулах боломжийг бүрдүүлэв. 2016 оны тариалалтын урьдчилсан дүнгээр 362.0 мянган га-д үр тариа, үүнээс 340.7 мянган га-д улаанбуудай, 19.2 мянган га-д төмс, хүнсний ногоо, 13.5 мянган га-д малын тэжээл, 50.0 мянган га-д тосны ургамал, нийтдээ 445.0 мянган га-д тариалалт хийсэн мэдээтэй байна. Буудайн тариалалт 113 хувийн биелэлттэй байна.	Хасах саналтай байна.	100

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ЯАМ